


**САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
2015 ОНЫ III УЛИРЛЫН ТОЙМ**
/Даатгал, Бичил санхүү, Хөрөнгийн зах зээл/



АГУУЛГА

БҮЛЭГ 1. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ	6
АНУ-ын хөрөнгийн зах зээл.....	6
Хятад улсын хөрөнгийн зах зээл	7
Хөгжиж буй орнуудын зах зээл	8
БҮЛЭГ 2. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ОРЧИН.....	11
2.1 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	11
Макро эдийн засгийн нөхцөл байдал	11
Дотоодын нийт бүтээгдэхүүн.....	11
Улсын төсөв	11
Хэрэглээний үнийн индекс.....	11
Санхүүгийн орчин.....	11
Банкны салбар	12
Банкнаас бусад санхүүгийн салбар	12
БҮЛЭГ 3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ	13
3.1 Үнэт цаасны зах зээлийн төлөв байдал.....	13
3.2 Хувьцаа болон компанийн өрийн хэрэгслийн зах зээл	16
3.3 Үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас.....	17
3.4 Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд	20
3.5 Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж.....	29
БҮЛЭГ 4. ДААТГАЛЫН САЛБАРЫН ТОЙМ.....	31
4.1 Салбарын гүнзгийрэлт буюу эдийн засагт үзүүлэх нөлөө	31
4.4 Даатгалын салбарын тогтвортой байдал.....	38
БҮЛЭГ 5. БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ	40
А. Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)	40
5.1 Банк бус санхүүгийн салбарын гүнзгийрэлт буюу эдийн засагт үзүүлэх нөлөө	40
5.2 Банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээний хүртээмж, олон улсын хандлага	42
5.3 Банк бус санхүүгийн салбарын үр ашигт байдал.....	44
5.4 Банк бус санхүүгийн салбарын тогтвортой байдал	46
Б. Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)	48
5.6 ХЗХ-ны үйлчилгээний хүртээмж.....	51
5.7 ХЗХ-ны үр ашигт байдал.....	52
В. Зээлийн батлан даалтын сан	54

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Хавсралт 1. Үнэт цаасны салбарын 2015 оны 3 дугаар санхүүгийн тайлангийн нэгтгэл.....	57
Хавсралт 2. Даатгалын компаниудын 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл	65
Хавсралт 3. Банк бус санхүүгийн байгууллагын 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл.....	68
Хавсралт 4. Хадгаламж зээлийн хоршоодын 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл.....	75

ХҮСНЭГТ

- Хүснэгт 1. ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүү
- Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн өмчийн хэлбэр
- Хүснэгт3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
- Хүснэгт4. Тусгай зориулалтын компани
- Хүснэгт 5. Зах зээлийн үнэлгээнд орсон өөрчлөлт
- Хүснэгт 6. Зохицуулалттай этгээдийн статистик мэдээ
- Хүснэгт 7. Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт
- Хүснэгт 8. Хөдөө аж ахуйн биржийн түүхий эдийн арилжаа
- Хүснэгт 9. Нийт хөрөнгөд эзлэх хувь
- Хүснэгт 10. Даатгалын компаниудын хөрөнгийг балансын зүйлээр
- Хүснэгт 11. Актив ба ДНБ-ийн харьцаа
- Хүснэгт 12. Нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь
- Хүснэгт 13. Даатгалын хураамжийн орлого
- Хүснэгт 14. Даатгалын нягтрал
- Хүснэгт 15. Ашигт ажиллагаа
- Хүснэгт 16. Даатгуулагч болон нөхөн төлбөр авсан тоо
- Хүснэгт 17. ББСБ-уудын статистикийн голлох үзүүлэлтүүд
- Хүснэгт 18. ББСБ-ын үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл
- Хүснэгт 19. ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүд
- Хүснэгт 20. Орлого, зарлага, ашигт ажиллагаа
- Хүснэгт 21. Зохистой харьцааны үзүүлэлт
- Хүснэгт 22. ХЗХ-дын нийт актив
- Хүснэгт 23. ХЗХ-дын зээлийн үзүүлэлт
- Хүснэгт 24. ХЗХ-дын олгосон зээлийн зориулалт
- Хүснэгт 25. ХЗХ-ын хадгаламж
- Хүснэгт 26. ХЗХ-дын өөрийн хөрөнгө
- Хүснэгт 27. Статистик мэдээлэл
- Хүснэгт 28. Батлан даалт гаргасан байдал
- Хүснэгт 29. Батлан даалтын тоо
- Хүснэгт 30. Зээлийн батлан даалтын хүртээмж
- Хүснэгт 31. Санхүүжилтын эх үүсвэр

ДҮРСЛЭЛ

- Дүрслэл 1. S&P 500 болон Dow Jones Industrials Average индекс
- Дүрслэл 2. Shanghai Composite Index
- Дүрслэл 3. IPO үнэт цаасны индексийн харьцуулалт
- Дүрслэл 4. Хятадын санхүүгийн тогтвортой байдлын индекс
- Дүрслэл 5. MSCI Emerging market index
- Дүрслэл 6. Арилжаанд эзлэх хувь
- Дүрслэл 7. 12 долоо хоногтой ЗГҮЦ
- Дүрслэл 8.28 долоо хоногтой ЗГҮЦ
- Дүрслэл 9.52 долоо хоногтой ЗГҮЦ
- Дүрслэл 10. Арилжааны хэмжээ
- Дүрслэл 11.Компанийн өрийн хэрэгслийн арилжаа
- Дүрслэл 12. Төлбөр гүйцэтгэсэн байдал
- Дүрслэл 13. Зах зээлийн үнэлгээ
- Дүрслэл 14. Зах зээлийн үнэлгээ өндөр компаниуд
- Дүрслэл 15. ЗЗҮ/ДНБ-ний харьцаа

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

- Дүрслэл 16. Хувьцааны төвлөрөл
- Дүрслэл 17. Хувьцааны арилжаа ба хөрвөх чадварын түвшин
- Дүрслэл 18. Арилжаанд эзлэх хувь
- Дүрслэл 19. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь
- Дүрслэл 20. Зах зээлийн үнэлгээ ба ТОП-20
- Дүрслэл 21. MSE ALL индекс
- Дүрслэл 22. Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны дүнд эзлэх хувь
- Дүрслэл 23. ХАА-н биржийн арилжаа
- Дүрслэл 24. Даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ
- Дүрслэл 25. Даатгалын салбарын нийт хөрөнгө
- Дүрслэл 26. Актив ба ДНБ-ийн харьцаа
- Дүрслэл 27. Хураамжийн орлого/ДНБ
- Дүрслэл 28. Даатгалын нягтрал
- Дүрслэл 29. Ашигт ажиллагаа
- Дүрслэл 30. ББСБ-ын нийт хөрөнгийн бүтэц
- Дүрслэл 31. ББСБ-ын нийт зээл, зээлийн чанар
- Дүрслэл 32. Бүртгэлтэй ББСБ-ын тоо
- Дүрслэл 33. Зээлийн хүү
- Дүрслэл 34. Хадгаламж, зээлийн хоршоодын активын өөрчлөлт
- Дүрслэл 35. ХЗХ-дын зээлийн чанар
- Дүрслэл 36. ХЗХ-ын өр төлбөр, өөрийн хөрөнгө
- Дүрслэл 37. ХЗХ-ын хадгаламжийн өсөлт
- Дүрслэл 38. ХЗХ-дын хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт
- Дүрслэл 39. ХЗХ-дын тооны өөрчлөлт
- Дүрслэл 40. ХЗХ-дын ашигт ажиллагаа

ЗУРАГ

- Зураг 1. Санхүүгийн үүсмэл зах зээлийн дэд бүтэц
- Зураг 2. Хүртээмжтэй даатгалын бодлогын дамжуулах механизм

ХАВСРАЛТ

- Хавсралт 1. Үнэт цаасны салбарын 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл
- Хавсралт 2. Даатгалын компаниудын 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл
- Хавсралт 3. Банк бус санхүүгийн байгууллагын 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл
- Хавсралт 4. Хадгаламж зээлийн хоршоодын 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл

БҮЛЭГ 1. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

АНУ-ын хөрөнгийн зах зээл: 2015 оны эхнээс өнөөг хүртэл 1 нэгж буюу 11 хувиар унаад байсан хувьцааны индексүүд эргээд Холбооны нөөцийн банкнаас эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, мөнгөний зөөлөн бодлого явуулсантай холбоотой оны эцэс рүү өсөх төлөв харагдаж байна. АНУ-ын хөрөнгийн зах зээлийн өсөлтийг илтгэн харуулагч гол индексүүд 2015 оны 11 дүгээр сарын 16-аас 20-ны өдрийг хүртэл 3 хувиар өсч, “S&P 500” 2,022.08-аас 2,089.17, “Dow Jones Industrials Average” 17,229.94-аас 17,823.81 тус тус болжээ.

Дүрслэл 1. S&P 500 болон Dow Jones Industrials Average индекс



Эх сурвалж: Блумберг

“Додд Франк¹” хууль: Зохицуулагч байгууллагууд (FDIC, SEC, OCC, Fed, SIPC гэх мэт)-ын зүгээс уг хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж байгаатай холбогдуулан 2016 онд хөрөнгийн болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн биржүүд зохицуулалтын илүү өндөр шаардлагыг хангах болж байна. Энэ хүрээнд Үнэт цаасны хороо хөрөнгийн зах зээлийн бүтэц нь зах зээлийн тогтворгүй байдал, хувьцааны үнийн хэлбэлзэлд сөргөөр нөлөөлж буй эсэхэд дүгнэлт гаргахаар болж байна. Үүнд бирж дээр арилжаалагддаг сангууд /ETFs/, биржийн бус багцын арилжаа /dark pools/ зэрэг мөн адил багтах аж.

Бараа, түүхий эдийн фьючерсийн арилжааны хорооны зүгээс алгоритмын арилжааг хязгаарлах, кибер аюулгүй байдлыг хангасан програм хангамжийг нэвтрүүлэх, төлбөр тооцооны байгууллагын үүрэг хариуцлагыг өндөрсгөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Шигтгээ 1:

Холбооны нөөц, Англи улсын төв банк мөнгөний бодлогоо чангаруулж, Европын холбоо болон Япон улсын төв банкууд бодлогын хүүгээ сулруулж байгаа өнөөгийн хөрөнгө оруулалтын нөхцлийгүндэслэвэл, 2015 оны эцэст санхүүгийн зах зээлийн төлвийг доорхи байдлаар таамаглаж байна.

- Олон улсын хувьцаа, түүний индексүүдийн хани өсч, бонд болон мөнгөний зах зээлийн санхүүгийн хэрэгслүүдээс давсан үзүүлэлтийг харуулна;
- Япон улс болон АНУ-ын хувьд олон улсын хувьцааны зах зээлийн хөдөлгөөнийг дагасан шинжийг харуулах бол хөгжиж буй орнуудын зах зээлийн индексүүд түүнээс доогуур гүйцэтгэлтэй байна;
- АНУ-ын ДНБ-ий өсөлт 3-аас дээш хувьтай гарч, инфляцийн түвшин 2 хувьд хүрнэ;
- АНУ-ын Засгийн газрын үнэт цаасны өгөөж 3 хувьд хүрнэ;

¹Санхүүгийн хямралаас үүдэлтэйгээр санхүүгийн шинэчлэл, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор АНУ-ын Конгрессээс 2010 онд баталсан хууль

- Жилийн эцэст “S&P 500” индекс 2150 нэгжид хүрнэ.

Мөн урт хугацаанд бондын хүүгийн түвшин бага хэмжээгээр өсөх бол хувьцааны өгөөж нэмэгдэнэ гэсэн төсөөлөл байна.

Эх сурвалж: 2015 Annual Global Outlook, Russel Investments

Хятад улсын хөрөнгийн зах зээл: “Shanghai Composite” индексийн өсөлт ажиглагдсанаар зах зээл эргэн сэргэх боломжтой гэдэг итгэл бий болсон. Зах зээл эргэн сэргэх нь дотоодын компаниудад үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлэх эх үүсвэрийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэх боломж нэмэгдэх бөгөөд арилжааны зээл авах нь багассанаар оргил түвшинд хүрээд байсан өрийн хэмжээ буурах төлөв ажиглагдаж байна.

“McKinsey Global Institute”-ээс 2014 онд Хятадын дотоодын компаниудын өр төлбөр, ДНБ-ий харьцаа 125 хувьд хүрсэн гэж тооцоолсон ба 2005 оны 1 дүгээр сараас хойш “Shanghai Composite” индексэд багтсан компаниудын нийт өр төлбөр, өөрийн хөрөнгийн харьцаа хамгийн өндөр түвшинд хүрсэн гэж дүгнэлээ.


Хятадын хөрөнгийн зах зээл сэргэж байгаа нь эргээд хувьцааны үнийг тогтвортой байлгах төрийн байгууллагын зохицуулалтын компани ажлыг эдийн засгийн өсөлт удааширч байгаатай холбогдуулан төрөөс хэрэгжүүлж буй мөнгөний бодлоготой уялдуулан зохион байгуулах нь оновчтой арга хэмжээ болно гэж зохицуулагчид үзэж байна.

Засгийн газрын одоогийн хэрэгжүүлж буй арга хэмжээ нь дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг хэвээр хадгалж байгаа хэдий ч гадаадын хөрөнгө оруулагчид Шанхай болон Хонконгийн бирж дээр хувьцаагаа зарах хандлага ажиглагдсаар байна.

Хятад улсын Үнэт цаасны зохицуулалтын хорооноос “... үнэт цаасны бүртгэлийн системийг сайжруулсны дараа л нийтэд санал болгон шинээр үнэт цаас гаргах боломжтой болно ...” гэж мэдэгдсэнээр үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоогоод байна.


Уг мэдэгдэл албан ёсоор гарах үед нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааг нийт 28 компани эхлүүлээд байсан ба энэ оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 10 компанийн үнэт цаасыг бүртгэх ажиллагааг 2 долоо хоногийн дотор хянаж шийдвэрлэх, үлдсэн 18 компанид энэ оны эцэст хувьцаагаа олон нийтэд худалдаж эхлэх боломжийг бүрдүүлнэ гэж тус хороо мэдээллээ.

Дүрслэл 2. Shanghai Composite Index



Эх сурвалж: Блүмберг

Хятад улсын Үнэт цаасны зохицуулалтын хороо мэдэгдэл хийхээс өмнө буюу баасан гарагт “Shanghai Composite” индекс 1.9 хувиар өсч, сүүлийн 11 долоо хоногийн дундаж руу дөхсөн хамгийн өндөр үзүүлэлт болсон ба улмаар уг индекс нь 2015 оны 8 дугаар сарын 26-ны өдөр 23 хувиар унаснаас хойш өндөр өсөлтийг харуулж 3610.314 нэгжид хүрээд байна.



Эх сурвалж: Блүмберг

“UBS групп”-ын Шанхай дахь салбарын шинжээч Wenjie Lu “... Засгийн газрын зүгээс IPO-гаргахыг дэмжих, нэмэгдүүлэх бодлого баримтлах зайлшгүй шаардлага үүсээд байна. Нөгөөтэйгүүр хөрөнгийн зах зээлийн гол үүрэг нь компаниуд бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтээ нийтэд санал болгон хувьцаа гаргах замаар хөрөнгийн эх үүсвэр татахад чиглэгдэх ёстой бөгөөд ингэснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд гол нөлөөг үзүүлдэг ...” хэмээн дүгнээд байна.

Блүмбэргээс шинээр “Хятадын санхүүгийн тогтвортой байдлын индекс”-ийг тооцож эхэлсэн бөгөөд уг индекс нь санхүүгийн тогтвортой байдалд учрах эрсдэлийг цаг хугацааны дарааллаар харуулахаар зорьжээ.

Дүрслэл 4. Хятадын санхүүгийн тогтвортой байдлын индекс



Эх сурвалж: Блүмберг

Дээрх индекс 2009 оноос хойш Хятадын санхүүгийн салбарт тодорхой хэмжээний эрсдэлүүд өсч байгааг харуулж байна. Эрсдэл бий болсон үндсэн шалтгаануудыг их хэмжээний зээл олголт, сүүдрийн банкны салбарын оролцоо нэмэгдсэн, хил дамнасан хөрөнгийн урсгалын хэмжээ өссөн, эдийн засгийн өсөлт удааширч байгаа зэрэгтэй холбоотой аж.

Хөгжиж буй орнуудын зах зээл: Зах зээлийн бууралт үргэлжилсэн өмнөх 5 жилийн үзүүлэлттэй харьцуулахад хөгжиж буй зах зээлтэй орнуудын эдийн засагт сэргэлт

ажиглагдаж эхлээд байгаа хэдий ч нийт активын бууралт явагдсан байна. “Goldman Sachs”, “Bank of America” зэрэг хөрөнгө оруулалтын банкуудын шинжээчид үүнийг сүүлийн 3 жилийн хувьцаа, валютын ханшийн алдагдлаас шалтгаалан буурсан гэж үзэж байна.

2012 оноос хойш хөгжиж буй зах зээлтэй орнуудын валютын ханш 30 хувиар унаад байсан нь хөрөнгө оруулагчдын алдагдлыг нэмэгдүүлсэн боловч энэ нь Бразил, Турк, Энэтхэг зэрэг орнуудад эдийн засгийн хүндрэлийг даван туулах, урсгал дансны алдагдлыг багасгах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлжээ.

Хөгжиж буй орнуудын зах зээлийн үнэлгээ 2011 оны өндөр өсөлтөөс хойш “Хөгжиж буй зах зээлийн индекс” 30 хувиар буураад байна. Өнөөгийн байдлаар нийт арилжааны дүн нь “S&P 500” индексийн зах зээлийн үнэлгээний гуравны нэгтэй тэнцүү хэмжээтэй байна.

Дүрслэл 5.MSCI Emerging market index



Эх сурвалж: Блүмберг

“Bank of America” хөрөнгө оруулалтын банкны тооцоолсон загварчлалын дагуу хөгжиж буй зах зээлтэй орнуудын валютын долларын эсрэг ханш бодит үнэ цэнээсээ дунджаар 16 хувиар унасан. Холбооны нөөцийн банкнаас 10 жилийн дотор анх удаагаа бодлогын хүүгээ өсгөхөөр шийдвэрлэсэн ч дээрх байдал хэвээр хадгалагдахаар байна. Гэвч “Bank of America” хөрөнгө оруулалтын банкны шинжээчид уг арга хэмжээ дунд хугацаанд хөгжиж буй зах зээлтэй орнуудын валютын ханш тогтвортой байхад эерэг нөлөө үзүүлнэ гэж дүгнэлээ.

АНУ-ын зээлийн хүүгийн түвшин нэмэгдэхтэй холбоотойгоор хөгжиж буй зах зээлтэй орнуудын компаниудад 1.4 их наяд ам.долларын өр төлбөрөө эргэн төлөхөд хүндрэл учруулж эхэлсэн. “Barclays” хөрөнгө оруулалтын банкны тооцоолж байгаагаар 2016 онд хөгжиж буй зах зээлтэй орнуудын доогуур үнэлгээтэй компаниуд төлбөрийн чадваргүй болж, дампуурах эрсдэл 7 хувьд хүрнэ гэж таамагласан ба энэ нь 2015 оны 3.8 хувь, 20 жилийн дундаж 4 хувиас харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Хятадын эдийн засаг нийлүүлэлтийн илүүдэл болон өрийн дарамтаас болж тэнцвэргүй байдалд хүрсэн. Эдийн засгийн өсөлт удааширч байхад юанийн ханшийг сулруулах арга хэмжээ авах шаардлагатайг олон улсын шинжээчдийн зүгээс Хятадын Засгийн газарт удаа дараа анхааруулж байна. Мөн Хятадын хөрөнгийн зах зээлийн хямрал нь Засгийн газрын зүгээс өсөлтийг дэмжих, шинэчлэл хийх зэрэг зөрчилдөөнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулж, бусад асуудлыг орхигдуулсантай холбоотой гэж “Barclays”-ийн шинжээчид үзжээ.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Хэдийгээр хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийж, өсөлтийг нэмэгдүүлэн тэлэх нь эрсдэлтэй хэдий ч мөн хэмжээний өгөөж хүртэх боломжийг агуулдгаараа онцлогтой. Иймээс хөгжиж буй зах зээл тогтворжих нь хөрөнгө оруулалт хийх дохио болно гэж “Morgan Stanley Investment management” компанийн Хөгжиж буй зах зээлийг харицсан захирал Ruchir Sharma үзэж байна.

БҮЛЭГ 2. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ОРЧИН

2.1 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд²

Макро эдийн засгийн нөхцөл байдал: Манай орны эдийн засаг дэлхийн зах зээл дэх эрдэс түүхий эдийн үнийн мөчлөгөөс хэт хамааралтайхөгжиж ирсэн бөгөөд сүүлийн 5 жилийн дунджаар экспортын 90 гаруй хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 гаруй хувь нь зөвхөн уул уурхайн салбарт ногдож байна.

2012 оноос олон улсын зах зээлд уул уурхайн болон олборлох салбарын түүхий эдийн үнэ ханш буурснаас манай орны экспортын болон гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом доошилсон нь эдийн засгийн өсөлтийг сааруулах үндсэн шалтгаан болов.

2015 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг Азийн хөгжлийн банкнаас 3 хувь, Олон улсын валютын сангаас 4.4 хувьд хүрнэ гэж тус тус таамаглаад байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн:³ 2015 оны 3 дугаар улирлын байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 оны зэрэгцүүлэх үнээр 11,558.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 286.4 тэрбум төгрөгөөр буюу 2.5 хувиар, харин тухайн оны үнээр 16,834.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 665.1 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар өсчээ.

Уг өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 9.8 хувь, аж үйлдвэр, барилгын салбарынх 8.3 хувиар өсч, харин бүтээгдэхүүний цэвэр татвар 16.5 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Улсын төсөв: Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2015 оны эхний 10 сард 4,569.3 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 5,484.6 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 915.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 636.8 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 12.7 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 206.0 тэрбум төгрөг буюу 5.0 хувиар буурахад онцгой албан татварын орлого 94.5 тэрбум төгрөг буюу 24.8 хувь, нийгмийн даатгалын орлого 56.2 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар өссөн хэдий ч нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 282.0 тэрбум төгрөг буюу 24.9 хувь, орлогын албан татварын орлого 41.5 тэрбум төгрөг буюу 4.9 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 36.1 тэрбум төгрөг буюу 11.9 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2015 оны эхний 10 сард 5,484.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 355.9 тэрбум төгрөг буюу 6.9 хувиар өсөхөд татаас 24.8 тэрбум төгрөг буюу 18.3 хувь, хөрөнгийн зардал 19.2 тэрбум төгрөг буюу 2.0 хувиар буурсан хэдий ч бараа, ажил үйлчилгээний зардал 148.2 тэрбум төгрөг буюу 7.2 хувь, урсгал шилжүүлэг 122.7 тэрбум төгрөг буюу 7.7 хувь, хүүгийн зардал 114.1 тэрбум төгрөг буюу 33.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2015 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.7 хувиар буурч, оны эхнээс 1.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 3.4 хувиар өссөн байна.

Санхүүгийн орчин: Олон улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг харахад, хөгжиж буй болон хөгжингүй зах зээлтэй орнууд санхүүгийн технологи, инноваци /FinTech/-д суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх замаар үйлчилгээний өртгийг бууруулан хүртээмж, гүнзгийрэлтийг дээшлүүлж, үр ашиг, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж

²Эх үүсвэр: Монгол банк

Үндэсний статистикийн хороо

³ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар тооцсон тоон мэдээллийг ашиглав.

байна. Манай орны санхүүгийн салбарын өнөөгийн нөхцөл, байдлаас харахад банкнаас бусад санхүүгийн салбарт технологи, инновацид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт дутагдаж байна.

Банкны салбар: Мөнгөний нийлүүлэлт 2015 оны эхний 10 сарын эцэст 9.9 их наяд төгрөг болж, өмнөх сарынхаас 14.0 тэрбум төгрөг буюу 0.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 52.8 тэрбум төгрөг буюу 0.5 хувиар буурчээ. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны 10 дугаар сарын эцэст 11.9 их наяд төгрөг болж, өмнөх сарынхаас 25.3 тэрбум төгрөг буюу 0.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 920.3 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар буурчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны 10 дугаар сарын эцэст 860.8 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 32.1 тэрбум төгрөг буюу 3.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 410.2 тэрбум төгрөг буюу 91.0 хувиар өсчээ. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2015 оны 10 дугаар сарын эцэст 855.5 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 18.6 тэрбум төгрөг буюу 2.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 249.2 тэрбум төгрөг буюу 41.1 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.2 хувийг эзэлж, өмнөх сарынхаас 0.2 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 2.5 пунктээр нэмэгдсэн байна.

Банкнаас бусад санхүүгийн салбар: 2015 оны 3 дугаар улирлын байдлаар зах зээлийн үнэлгээ 1289.8 тэрбум төгрөг байгаа нь өмнөх улиралтай харьцуулахад 8.43 хувь буюу 118.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Монголын хөрөнгийн биржийн 188 удаагийн арилжаагаар хувьцааны анхдагч зах зээлд 151 мянган ширхэг хувьцааг 112.6 сая төгрөг, хоёрдогч зах зээлд 115 компанийн 19.97 сая ширхэг хувьцааг 6.92 тэрбум төгрөгөөр, нийт 20.1 сая ширхэг хувьцааг 7.03 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Засгийн газрын үнэт цаасны 38 удаагийн арилжаагаар анхдагч зах зээлд 4.2 сая ширхэг үнэт цаасны 403.47 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд 28.1 мянган ширхэг үнэт цаасны 2.76 тэрбум төгрөг, нийт 406.23 тэрбум төгрөгийн арилжаа явагдлаа. Компанийн бондын анхдагч зах зээлд 500.0 сая төгрөгөөр 50.0 мянган ширхэг, хоёрдогч зах зээлд 1.86 сая төгрөгөөр 203 ширхэг бонд арилжигдлаа.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 169.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 34.5 тэрбум төгрөгөөр буюу 25.5 хувиар өслөө.

Мөн хугацаанд тусгай зөвшөөрөл бүхий 442 банк бус санхүүгийн байгууллагуудын нийт актив 581.9 тэрбум төгрөгт хүрч, нийт зээлийн багцын үлдэгдлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 89.4 тэрбум төгрөгөөр буюу 34 хувиар нэмэгдэж, нийт зээлийн багцад хугацаа хэтэрсэн зээл 5.8 хувь, чанаргүй зээл 9.1 хувийг эзэлж байна.

Хадгаламж зээлийн хоршоодын нийт активын хэмжээ 93.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд нийт зээлийн үлдэгдэл 62.2 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 3.5 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 2.7 хувийг эзэлж байна. Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 57.1 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 61.2 хувийг эзэлж байна.

БҮЛЭГ 3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

3.1 Үнэт цаасны зах зээлийн төлөв байдал


Засгийн газрын үнэт цаасны зах зээл: Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны анхдагч болон хоёрдогч арилжаа Монголбанк, “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр явагдаж байна.

Дүрслэл 6. Үнэт цаасны арилжаа /хувиар/




ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа: 2015 оны 3 дугаар улирлын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр 42 удаагийн арилжаагаар 4.2 сая ширхэг ЗГҮЦ нийт 403.47 тэрбум төгрөгөөр арилжигдсанаас, 12 долоо хоногтой ЗГҮЦ 72.15 хувь, 28 долоо хоногтой үнэт цаас 15.47 хувь, 52 долоо хоногтой үнэт цаас нийт арилжааны 12.37 хувь, 3 болон 5 жилийн урт хугацаатай үнэт цаас 0.01 хувийг тус тус эзэлж байна. “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр арилжигдаж буй ЗГҮЦ-ыг хүү болон арилжааны хэмжээг дүрслэлээр дор үзүүлэв.

Дүрслэл 7.12 долоо хоногтой ЗГҮЦ




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Дүрслэл 8.28 долоо хоногтой ЗГҮЦ



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Дүрслэл 9.52 долоо хоногтой ЗГҮЦ



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Тайлант хугацаанд 329 хөрөнгө оруулагч ЗГҮЦ-ны анхдагч зах зээлээс нийт 2,201,543 ширхэг үнэт цаасыг худалдан авлаа. Өссөн дүнгээр ЗГҮЦ-ны үндсэн ба хүүгийн төлбөрт 371.6 тэрбум төгрөг төлөгдсөн байна.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа: Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн ЗГҮЦ-ны хоёрдогч арилжаагаар 28.1 мянган ширхэг үнэт цаасыг нийт 2.76 тэрбум төгрөгөөр арилжаалсан бөгөөд арилжааны идэвхжилтийг шинээр нэвтрүүлснийг нийт 4 ҮЦК итгэмжлэгдсэн дилерийн эрхтэйгээр хэрэгжүүлж байна.

Арилжаанд “Ард капитал” ХХК, “Голомт секьюритиз” ХХК, “Дэү секьюритиз” ХХК, “Гацуурт трейд” ХХК, “БиДиСек” ХК, “Стандарт инвестмент” ХХК, “Блюмсбюри секьюритиз” ХХК, “Тэнгэр капитал” ХХК зэрэг үнэт цаасны компаниуд идэвхитэй оролцов.

Хүснэгт 1. ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүү


Д/д	Хугацаа	Нийт дүн	Жигнэсэн дундаж хүү	Эзлэх хувь
1	12 долоо хоног	3,010,510	14.860%	71.10%
2	28 долоо хоног	672,692	14.453%	15.89%
3	52 долоо хоног	550,337	14.989%	13.00%
4	156 долоо хоног	355	16.875%	0.01%
5	260 долоо хоног	20	16.750%	0.00%
Нийт		4,233,914		100.00%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Тайлант хугацаанд Монголбанкаар 12, 28 долоо хоног, 1 ба 2 жилийн хугацаатай нийт 1,199.7 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалагджээ.

Монголбанк болон Монголын хөрөнгийн биржээр нийт 1,603.2 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалагдсан бөгөөд арилжааны хувь хэмжээг дүрслэлээр дор үзүүлэв.

Дүрслэл 10. Арилжааны хэмжээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны дүнгээс харахад 12 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ-ны нийлүүлэлт зонхилж байна. Манай орны хувьд ЗГҮЦ-ны хүүг бууруулах, урт хугацааны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар төсөвт учрах дарамтыг бууруулах, хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхжүүлэх шаардлага тулгараад байна.

Шигтгээ 2:

Монголбанкнаас зохион байгуулсан арилжаанд цөөн тооны томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчид, банкууд голчлон оролцож байгаа тул цаашид биржийн арилжааг жижиглэнгийн чиглэлээр хөгжүүлэх нь зохистой. Мөн ЗГҮЦ-ны олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагааны интеграцид нэгдэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн зэрэглэл тогтоох байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг манай оронд үйл ажиллагаа эрхлэх чиглэлд дэмжлэг үзүүлэх шаардлага үүсээд байна. Олон улсын санхүүгийн зах зээлд Евро бүсийн болон АНУ-ын Засгийн газрын бонд томоохон хувийг илтгэдэг хэдий ч сүүлийн жилүүдэд Азийн бүсийн тэр тусмаа ASEAN+3 орнуудад бондын зах зээл эрчимтэй хөгжиж байна. Учир нь Азийн орнуудын эдийн засгийн бүтэц нь ЖДҮ давамгайлсан, дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эх үүсвэр хангалттай бус зэргийг харгалзан хөрөнгө татан төвлөрүүлэх үйл явцыг бүс нутгийн хэмжээнд Засгийн газрын бондын арилжааг идэвхжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

3.2 Хувьцаа болон компанийн өрийн хэрэгслийн зах зээл

Хувьцааны арилжаа: Тайлант хугацаанд Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын өмчлөлийн хэлбэрийг үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт2. Үнэт цаас гаргагчийн өмчийн хэлбэр

Үнэт цаас гаргагчийн өмчийн хэлбэр	Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй	“Монголын хөрөнгийн бирж” ХК-нд бүртгэлтэй	“ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэлтэй
Төрийн өмчит	32	21	19
Төрийн өмчийн оролцоотой	11	15	11
Орон нутгийн оролцоотой	15	-	15
Хувийн өмчит	245	199	276
Нийт	303	235	321

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 188 удаагийн арилжаагаар нийт 115 компанийн 7.03 тэрбум төгрөгийн 20.1 сая ширхэг хувьцаа арилжигдсан нь нийт үнэт цаасны арилжааны 1.70 хувийг эзлэв.

Хувьцааны арилжааны 21.80 хувь буюу 1.53 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 78.2 хувь буюу 5.50 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлэв. Идэвхтэй арилжигдсан 30 компанийн үнэт цаасны арилжаа нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 89.9 хувь, арилжигдсан тоо, ширхэгийн 98.66 хувийг эзэлжээ. Багцын арилжаанд голчлон мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчид оролцож хувьцаат компаниудын хяналтын багцыг худалдах, худалдан авах гүйлгээ хийгдсэн бөгөөд энгийн арилжаанд өмч хувьчлалын эрхийн бичгээр эзэмшсэн цөөн тооны хувьцааны арилжаа зонхилж байна. Тус Хорооноос 2012 онд Монголын хөрөнгийн биржийн багцын арилжааг зохицуулах чиглэлээр холбогдох шийдвэрүүдийг гаргасан бөгөөд багцын арилжаа нь үнэт цаасны индекс, хувьцааны хаалтын үнэ, ханшид нөлөөлөхгүй байдлаар зохицуулагдсан.

Хувьцааны арилжаа идэвхгүй байгаад нэг талаас уул уурхайн болон боловсруулах салбарын хувьцаат компаниудын хувьцааны үнэ ханш унаж, гадаадын хөрөнгө оруулагчдын хувьцаанд хөрөнгө оруулах сонирхол буурсан, макро эдийн засгийн нөхцөл муудсантай холбоотой хэдий ч нөгөө талаас үнэ тогтолт шударга тогтож байгаа эсэхээс хамаарч байх талтай.

Шигтгээ 3:

Хувьцааны зах зээлийн өнөөгийн нөхцлийг харахад хөрөнгө оруулагчид эрэлт хэрэгцээндээ нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээсэн байдалтай, харин компаниуд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, нэр хүндээ өсгөх чиглэлээр үнэт цаасаа олон нийтэд санал болгох бэлтгэл ажлуудыг хангахаар ажиллаж байна.


Үнэт цаасны зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бизнесийн шинэ санаа, санаачлагыг дэмжих, санхүүжилтийн урт хугацааны эх үүсвэрийг бий болгох үндсэн хэрэгсэл нь олон нийтэд үнэт цаасаа санал болгон гаргах ажиллагаа. Олон улсын үнэт цаасны зохицуулах байгууллагуудын холбоо /IOSCO/-ноос өөрийн гишүүн байгууллагуудад хандаж хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ил тод, тунгалаг, тогтвортой зах зээлийг бий болгохын тулд үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах ажиллагаанд зохицуулалт, хяналтыг онцгойлон чиглүүлэхийг зөвлөж байна.

Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс олон нийтэд үнэт цаасаа санал болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд бүртгэлийг шинэчлэх ажлыг хийж байна.

Төв банкны бодлогын хүүгээр дамжуулан зээл, хадгаламжийн хүүг бууруулах, лангууны арынзах зээл /ОТС/-ийг хөгжүүлэх, үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх санхүүгийн хөшүүргүүд болох маржин арилжаа, үнэт цаас зээлдүүлэх, ханшийн эрсдэлээс хамгаалах механизмуудыг ашигладаг болох, давхар бүртгэл, хадгаламжийн бичгийг идэвхжүүлэх шаардлагатай тул Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн хэрэгслийг бүртгэх журмын төслүүдийг боловсруулж байна.

Компанийн бондын арилжаа: Тайлан хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК нь “Эрчим инженеринг” ХХК-ийн нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50.0 мянган ширхэг “Эрчим” бондыг 500.0 сая төгрөгөөр олон нийтэд арилжаалсан байна. 2012 оноос хойш компанийн өрийн хэрэгсэл “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр арилжаалагдаагүй бөгөөд “Эрчим инженеринг” ХХК-ийн бонд нь даатгагдсан гэдэг утгаараа хөрөнгө оруулагчдын сонирхол, зах зээлийн хөгжлийн чиг хандлагад эерэг нөлөөг үзүүлээ. Компанийн өрийн хэрэгслийн бүтээгдэхүүн, үйлчилгээ өндөр эрэлттэй байгаа нь харагдаж байна.

Дүрслэл 11. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Гадаадад гаргасан өрийн бичиг: Монгол Улсын Засгийн газар болон компаниуд 2010 оноос хойших хугацаанд Сингапур болон Токиогийн хөрөнгийн бирж дээр 8 төрлийн өрийн бичиг гаргаж 30.0 тэрбум иенийн, 2,475.0 сая ам долларын, 700.0 сая юанийн хөрөнгө оруулалтыг татжээ.

Шигтгээ4:

Санхүүгийн зохицуулах хорооноос бүртгэлийн журмаарзөвхөн компанийн барьцаат өрийн хэрэгслээс гадна бусадсанхүүгийн активаар баталгаажсан өрийн хэрэгслийг бүртгэх зохицуулалтыг бий болгов.

3.3 Үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас


Улсын Их Хурлаас 2013 онд батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар үүсмэл үнэт цаасыг бүртгэх, арилжаалах зохицуулалтын орчинг бүрдүүлсэн бөгөөд Люксембургийн Вант улсын “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл”-тэй хамтран үнэт цаасны зах зээлд санхүүгийн үүсмэл хэрэгслийг бий болгох чиглэлээр холбогдох сургалт, судалгааны ажлууд хийгдэж байна.

Шигтгээ 5:

Суурь үнэт цаасны зах зээл хэрхэн төлөвшсөнөөс шалтгаалан үүсмэл болон хөрөнгөөр баталгаажсан санхүүгийн хэрэгсэл амжилттай хөгжих бөгөөд үүсмэл санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, санхүүгийн хөшүүргүүдийг биржийн арилжаанд нэвтрүүлэх суурь дэд бүтэц бүрэлдэн бий болж байна.

IOSCO-оос төлбөр тооцооны чиг үүргийг бие даасан байгууллага дагнан эрхлэх, уг хуулийн этгээд нь номинал данс эзэмшигч компаниудын гишүүнчлэл бүхий Өөрийгөө зохицуулах байгууллага хэлбэрээр үйл ажиллагаа явуулахыг зөвлөсөн. Одоогоор “ҮЦТТТХТ” ХХК нь үнэт цаасны төлбөрийн, тооцооны, хадгаламжийн чиг үүргийг давхар гүйцэтгэж байгаа төлбөр, тооцоо болон хадгаламжийн чиг үүргийг нь салгаж, үйл ажиллагааг нь бие даасан хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх замаар олон улсын стандартыг нэвтрүүлэх боломжтой.

Зураг 1. Үнэт цаасных зах зээлийн дэд бүтцийн өнөөгийн байдал



Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас: Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл бүхий 6 тусгай зориулалтын компаниуд нь нийт 42,374 зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр баталгаажсан 1,909.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий баталгаат үнэт цаас гаргасан бөгөөд нийт 111,08 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгдсөн байна.

Хүснэгт3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас			
Үнэт цаас гаргагч	Нийт гаргасан баталгаат үнэт цаас /тэрбум төгрөг/	"ҮЦТТТХТ" ХХК-д бүртгэсэн үнэт цаас /тэрбум төгрөг/	Зээлдэгчдийн тоо /мянга/
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	7.9
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.05	5.9
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	7.1
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9.9
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5.9
“МИК актив зургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,258
Нийт	1,909.8	1,877.9	5,294.7

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт4. Тусгай зориулалтын компани

№	Компанийн нэрс	Хорооны тогтоолын дагуу	"ҮЦТТТХТ" ХХК бүртгэсэн /тэрбум төгрөг/	2015.09.30-ны үлдэгдэл /тэрбум төгрөг/	Төлөгдсөн үндсэн төлбөр /тэрбум төгрөг/

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм


1	МИК актив 1 ТЗК	Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн	328.2 тэрбум төгрөг хүртэл	322.9	269.4	53.5
		Зээлдэгчдийн тоо	7,917	7,853	6,989	
2	МИК актив 2 ТЗК	Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн	224.8 тэрбум төгрөг хүртэл	222.1	202.2	19.9
		Зээлдэгчдийн тоо	5,937	5,898	5,495	
3	“МИК актив 3 ТЗК	Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн	328.5 тэрбум төгрөг хүртэл	324.6	306.7	17.9
		Зээлдэгчдийн тоо	7,105	7,059	6,814	
4	“МИК актив 4 ТЗК	Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн	459.4 тэрбум төгрөг хүртэл	452.3	436.9	15.4
		Зээлдэгчдийн тоо	10,034	9,961	9,753	
5	“МИК актив 5 ТЗК	Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн	301.2 тэрбум төгрөг хүртэл	294.3	289.5	4.5
		Зээлдэгчдийн тоо	6,052	5,997	5,945	
6	“МИК актив 6 ТЗК”	Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн	267.8 тэрбум төгрөг хүртэл	261.7	261.7	
		Зээлдэгчдийн тоо	5,329	5,227	5,258	

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлээр буюу Монголбанк болон “Монголын ипотекийн корпораци” ХХК-ийн хооронд арилжаа явагдаж байна.

Үнэт цаасны төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламж: Тайлант хугацаанд “ҮЦТТТХТ” ХХК нь 645 харилцагчийн дансанд 2581 удаагийн 2,286.1 тэрбум төгрөгийн орлогын, 2504 харилцагчийн 3637 удаагийн 2,286.8 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус хийжээ. Мөн “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны төлбөр тооцоо болох “Голомт банк” ХХК-ийн 2.3 тэрбум, “Худалдаа хөгжлийн банк” ХХК-ийн 747.3 сая, “Хас банк” ХХК-иар 2.4 тэрбум, “ХААН банк” ХХК-иар 65.6 сая төгрөгийн банк хоорондын гүйлгээг тус тус хийжээ.

Дүрслэл 12. Төлбөр гүйцэтгэсэн байдал



Эх сурвалж: “ҮЦТТТХТ” ХХК

Тайлант хугацаанд “ҮЦТТТХТ” ХХК 16105 данс шинээр, 1574 данс холболтоор нээсэн ба харилцагчийн бүтцээр нь үзвэл, дотоодын иргэд 16015, гадаадын иргэн 48, дотоодын аж ахуйн нэгж 39, гадаадын аж ахуйн нэгж 3 дансыг тус тус нээлгэсэн нь өмнөх оны мөн үеэс 2 дахин нэмэгдсэн нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг буцаан эзэмшүүлэн бүртгэх тухай 2015 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Засгийн газрын 151 дүгээр тогтоол гарсны дагуу эх орны хувь хишиг хүртэхээр өргөдлөө гаргасан бүх иргэнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг буцаан эзэмшүүлэн бүртгэх ажлыг “ҮЦТТТХТ” ХХК гүйцэтгэсэн нь нөлөөлжээ.

Шигтгээ 6:

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлснээс хойших хугацаанд төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр шинээр 801,986, холбоолтоор 134,986 данс тус тус нээгдсэн бөгөөд харилцагчийн бүтцээр дотоодын иргэд 797,509 гадаадын иргэд 1,811, дотоодын аж ахуйн нэгжүүд 2,472, гадаадын аж ахуйн нэгж 176 дансыг тус тус нээлгэсэн байна.


“ҮЦТТТХТ” ХХК-иар дамжуулан өв залгамжлалаар 434 удаагийн гүйлгээгээр давхардсан тоогоор 102 ХК-ийн 220,195 ширхэг хувьцаа, мөнгөн хөрөнгийн 64.9 сая төгрөгийн гүйлгээг, бэлэглэлээр 27 удаагийн гүйлгээгээр давхардсан тоогоор 13 ХК-ийн 562,417 ширхэг хувьцааг, Шүүхийн шийдвэрээр хоёр харилцагчийн 2 ХК-ийн 10,579 ширхэг хувьцааг шилжүүлж, 128,706.86 төгрөгийн гүйлгээг тус тус хийсэн байна.

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын уялдааг сайжруулж, Төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй харилцагчийн дансуудыг багцлан кастодиан банкны номинал дансны хэлбэрт шилжүүлэх, кастодиан банктай мэдээллийн тулгалт хийх програм хангамжийг боловсронгуй болгох ажил “ҮЦТТТХТ” ХХК ба Хорооноос тусгай зөвшөөрөл авсан кастодиан банкууд дээр хийгдэж байна.

3.4 Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд


Үнэт цаасны зах зээлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл: Олон улсын байгууллагууд болон хөгжингүй зах зээлтэй орнуудад үнэт цаасны зах зээлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээ, арилжааны хэмжээгээр дүгнэдэг. 2015 оны 3 дугаар улирлын байдлаар зах зээлийн үнэлгээ 1289.8 тэрбум төгрөг байгаа нь 2014 оны жилийн эцэстэй харьцуулахад 152.8 тэрбум төгрөгөөр буюу 10.6 хувиар, өмнөх улиралтай харьцуулахад 8.43 хувь буюу 118.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Дүрслэл 13. Зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нийт 30 хувьцаат компанийн зах зээлийн үнэлгээ нийт зах зээлийн үнэлгээний 88.19 хувийг эзэлж байна. Дээрх компаниудыг хүснэгтээр үзүүлбэл:



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Мөн хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй 235 компаниас 74 компанийн зах зээлийн үнэлгээнд орсон өөрчлөлтийг салбараар нь ангилан хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 5. Зах зээлийн үнэлгээнд орсон өөрчлөлт /салбараар/

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хувьцааны зах зээлийн үнэлгээ буурахад уул уурхай, барилга, үйлчилгээний салбаруудын бууралт нөлөөллөө. 2015 оны 2 дугаар улиралд 33.4 хувийн өсөлттэй байсан нь 2015 оны 6 дугаар сард “Оюу толгой” компанийн далд уурхайн төслийн үйл ажиллагаа эхлүүлэх гэрээнд гарын үсэг зурахтай холбоотой уул уурхайн компаниудын хувьцаа худалдан авах эрэлт нэмэгдсэн хэдийн ч тайлант улиралд эрэлт эргэж буурлаа.

Барилгын салбарт “УБ БҮК” ХК, “Гермес центр” ХК, “Мерекс” ХК-иудын хувьцааны үнэлгээ 7.9 тэрбум төгрөгөөр буурчээ. Харин үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг “Улсын их дэлгүүр” ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2.6 тэрбум төгрөгөөр өссөн ч бусад “Би Ди Сек” ХК, “Женко тур бюро” ХК, “Материалимпекс” ХК-иудын хувьцааны үнэлгээ 10 тэрбум төгрөгөөр буурсан нь салбарын хэмжээнд бууралт үүсэхэд голлон нөлөөлөв.

Тайлант улиралд үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгө, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын зах зээлийн багтаамж нэмэгдсэн байна. “Сүү” ХК-ийн үнэлгээ 9.6 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч “Гутал” ХК, “Монгол нэхмэл” ХК, “Хай Би Ойл” ХК-иудын хувьцааны үнийн өсөлт зах зээлийн үнэлгээг 26.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээр үйлдвэрлэлийн салбарын үнэлгээг өсгөхөд нөлөөлжээ. Мөн хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулдаг “Бинсэ” ХК хувьцаа нэмж гаргаснаар үнэлгээгээ 0.84 тэрбум төгрөгөөр буюу 91 хувиар, үл хөдлөх хөрөнгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг “Тахь Ко” ХК-ийн үнэлгээ 5.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2015 оны 3 дугаар улирлын байдлаар ДНБ-д эзлэх зах зээлийн үнэлгээний дүн 7.6 хувь, нийт арилжааны дүн 2.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс зах зээлийн үнэлгээ 2 хувиар


буурсан бол арилжааны хэмжээ 1.4 хувиар өсчээ. Энэ нь Азийн хөгжингүй болон хөгжиж буй үнэт цаасны зах зээлтэй орнуудын тоон үзүүлэлтүүдтэй харьцуулахад 2-5 дахин доогуур түвшинд байлаа.

Хөгжингүй эдийн засагтай орнуудын хувьд эдийн засгийн өсөлтөд үнэт цаасны зах зээлийн үзүүлэх нөлөөлөл өндөр, урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг хангах үндсэн хэрэгсэл болдог бол хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн өсөлтөөс үнэт цаасны зах зээлийн хөгжил нь шууд хамаарах хандлагатай байдаг бөгөөд манай улсад ч мөн ажиглагдаж байна.

Шигтгээ 7:

Эдийн засгийн өсөлтөд үзүүлэх үнэт цаасны зах зээлийн үүргийг нэмэгдүүлэх хөгжлийн цогц бодлого, стратеги баталж, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж Санхүүгийн зохицуулах хорооноос үзэж байгаа бөгөөд урт хугацааны хөгжлийн стратегийн төслийг Монголбанк, Сангийн яамтай хамтран боловсруулж, хууль тогтоох дээд байгууллагад хүргүүлэхээр бэлдэж байна.

Дүрслэл 15. ЗЗҮ/ДНБ-ний харьцаа /2014 оны байдлаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж: Үнэт цаасны зах зээлд шинээр өөрийгөө зохицуулах байгууллага 2, арилжаа эрхлэх 1, кастодианы банкны 1, хувийн хөрөнгө оруулалтын сангийн 1, нэмж хөрөнгө оруулалтын зөвлөхийн 1, андеррайтерийн 1 тусгай зөвшөөрлийг тус тус олгоод байна. Тайлант хугацаанд тус Хорооноос 6 зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

Хүснэгт 6. Зохицуулалттай этгээдийн статистик мэдээ

№	Зохицуулалттай этгээдийн статистик мэдээ	2015 он
		3-р улирал
1	Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн тоо: Үүнээс	81
1.1	Брокер	61
1.2	Дилер	59
1.3	Андеррайтер	24
1.4	Хөрөнгө оруулалтын зөвлөх	16
1.5	Хөрөнгө оруулалтын менежмент	3
1.6	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
1.7	Үнэт цаасны төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламж	1
1.8	Өөрийгөө зохицуулах байгууллага	1
1.9	Хөрөнгө итгэмжлэн удирдах	0
1.10	Төлбөр гүйцэтгэгч банк	5

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

1.11	Засгийн газрын үнэт цаас зуучлан борлуулах үйлчилгээ /банк/	10
1.12	Кастодиан банк	3
1.13	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах	4
1.14	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компани	27

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн 2014, 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, өмнөх онуудын шалгалтын тайлангийн нэгтгэл, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны тайлангийн судалгаанаас харахад мэргэжлийн зуучлагч байгууллагуудын хүний нөөц, санхүүгийн чадавхи сул байгаагийн улмаас нийгмийн зорилтот бүлгүүдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, санал болгох ажиллагаа идэвхгүй, зах зээлд хувьцаа, Засгийн газрын болон компанийн өрийн хэрэгсэл гэсэн цөөн тооны хэрэгсэл арилжаалагдаж байна.


2005 оноос хойших хугацаад нийт андеррайтерийн 7 компани үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргах зуучлалын үйлчилгээг хүргэсэн байгаа нь цаашид андеррайтерийн үйлчилгээний цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

Цаашид үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч этгээдүүдийн чадавхийг сайжруулах, тооноос чанарт шилжүүлэх, үйлчилгээний нэр хүндийг өсгөх чиглэлээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх чиглэлээр Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журмыг шинэчлэн боловсрууллаа.

Түүнчлэн олон нийтийн санхүүгийн болон хөрөнгө оруулалтын суурь боловсрол хангалтгүй, сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө үнэт цаасанд байршуулахаас илүүтэйгээр банкны хадгаламжид байршуулах сонирхол өндөр байгаа нь Монголбанкнаас боловсруулсан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2016-2021”-ийн судалгааны тайланд тусгагдсан.

Нийт бүртгэлтэй хувьцаат компаниудын 5-аас дээш хувийг нийт 1049 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр 801.9 мянган иргэн, аж ахуйн нэгжийн данс бүртгэлтэй байгаа хэдий ч үнэт цаасны арилжаанд 10 мянган харилцагч идэвхтэй оролцож байна.

Дүрслэл 16. Хувьцааны төвлөрөл



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Үнэт цаасны зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд үнэт цаасны компаниуд нийгмийн бүлгүүдэд чиглэсэн, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр санал болгох, гадаад дотоодын томоохон хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах чиглэлд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах шаардлагатай.

Шигтгээ 8:

Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас Хороотой хамтран хэрэгжүүлж буй “Хөрөнгийн зах зээлийг чадавхжуулах” төслийн хүрээнд үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажлын хүрээнд Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимтай хамтран ТОП-100 аж ахуй нэгжүүдийн хүрээнд семинар зохион байгуулан үнэт цаасны зах зээлээс санхүүжилт босгохын давуу талыг танилцуулсан. Мөн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын сургалтыг зохион байгуулж ажиллаа.

Үнэт цаасны зах зээлийн үр ашигт байдал: 2015 оны 3 дугаар улирлын байдлаар нийт арилжаалагдсан хувьцааны дүнг тайлант оны зах зээлийн үнэлгээнд харьцуулан тооцоход хөрвөх чадварын түвшин 0.55 хувь байна. Үүнд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хувьцааны арилжааны хэмжээ буурсан, нийт бүртгэлтэй хувьцаат компанийн төвлөрөлийн хувь өндөр хэвээр, шинээр болон нэмж үнэт цаас бүртгэгдээгүйбайгаа нь тус тус нөлөөлжээ.

Дүрслэл 17. Хувьцааны арилжаа ба хөрвөх чадварын түвшин



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Шигтгээ 9:

Хөрвөх чадварын түвшин нь хувьцааны зах зээлийн эргэц, хурдыг илэрхийлэх бөгөөд хөгжингүй зах зээлтэй орнуудад дээрх харьцааны түвшин 70-90 хувьтай байна. Харин хөгжиж байгаа зах зээлтэй орнуудад хөрвөх чадварын түвшинг нэмэгдүүлэхэд хөрөнгийн биржүүд маркет мэйкер, үнэт цаас зээлээр худалдах, худалдан авахарга хэрэгслүүдийг өргөн ашиглаж хөрөнгө оруулагчдыг тухайн зах зээлд татдаг.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжаанд эзлэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бүтцийг 2015 оны 3 дугаар улирлын байдлаар авч үзвэл дотоодын иргэн 22.9 тэрбум төгрөг, гадаадын иргэн 4.6 тэрбум төгрөг, дотоодын аж ахуйн нэгж 383.4 тэрбум төгрөг, гадаадын аж ахуйн нэгж 2.6 тэрбум төгрөгөөр тус тус арилжаанд оролцжээ.


Дүрслэл 18. Арилжаанд эзлэх хувь



Эх сурвалж: “ҮЦТТТХТ” ХХК

Тайлант хугацаанд Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцсон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл 19. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны бүтэц



Эх сурвалж: “ҮЦТТТХТ” ХХК

Гадаадын иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үнэт цаасны арилжаанд оролцох хувь хэмжээ тасралтгүй буурахад макро эдийн засгийн нөхцөл байдал, үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар хангалтгүй, Монголын хөрөнгийн биржид арилжигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, дутмаг, тэдгээрийн эрхийг хамгаалах тогтолцоо бүрдээгүй, гадаад валютын үнэ ханшний хэлбэлзэлтэй байгаа байдал тус тус нөлөөлж байна. Үнэт цаасны зах зээлийн арилжааг идэвхжүүлэх чиглэлээр татварын таатай орчинг бүрдүүлэх, гадаадын томоохон хөрөнгө оруулалтын банкны салбар төлөөлөгчийн газраа байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр санхүүгийн чөлөөт бүсийг бий болгох шаардлагатай.

Үнэт цаасны зах зээлийн ил тод, тогтвортой байдал: Үнэт цаасны зах зээлийн ил тод, тогтвортой байдлыг тайлагнал, мэдээллийн ил тод болон үнэ ханшийн тогтвортой байдал, төрийн зохицуулах байгууллагын оновчтой хяналт, зохицуулалтаар тодорхойлогдөг бөгөөд 2015 оны 3 дугаар улирлын байдлаар:

Олон улсын үнэт цаасны зохицуулах байгууллагуудын холбоо /IOSCO/-оос үнэт цаасны зах зээл дэх тайлагналын ил тод байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг хангах, хэрэгжилтэд үнэлгээ хийх чиглэлээр тус Хорооны даргын тушаалаар зохицуулалттай этгээдүүдийн төлөөллийг оролцуулсан хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Мөн Олон улсын санхүүгийн корпораци /IFC/, Компанийн засаглалын хөгжлийн төвтэй хамтран ARAM төслийг хэрэгжүүлж байна.

2015 оны 3 дугаар улирлын байдлаар 303 хувьцаат компани Хороонд бүртгэлтэйгээс 145 хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлж, 133 хувьцаат компани хурлаа хуралдуулж, 173 хувьцаат компани санхүүгийн тайлангаа ирүүлээд байна.

Хүснэгт 7. Хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компанийн тоо	Санхүүгийн тайлан ирүүлсэн компанийн тоо	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан компанийн тоо	Ногдол ашиг хуваарилсан компанийн тоо
145 ХК	173 ХК	133 ХК	23 ХК
47.85%	57.09%	43.89%	7.59%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин бүртгэлтэй нийт хувьцаат компаниас үнэт цаасны арилжаа нь зогссон 90 хувьцаат компани, 100 хувь төрийн өмчийн 32, төрийн өмчийн оролцоотой 11 болон орон нутгийн оролцоотой 15 хувьцаат компанийг хасч, “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр хувьцаа нь тодорхой хэмжээнд идэвхитэй арилжаалагддаг, хэвийн 155 хувьцаат компани үйл ажиллагаа эрхэлж байна.


2015 оны 3 дугаар улирлын байдлаар 23 хувьцаат компани нийт 199,854,730 ширхэг хувьцаанд ногдох нийт 7.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн бол 4 хувьцаат компани хаалттай компани болох хүсэлтийг гаргасныг Хорооноос шийдвэрлэн хувьцаа эзэмшигчдэд ногдох ногдол хувийн мөнгийг “ҮЦТТТХТ” ХХК-д байршуулахыг үүрэг болгосон.

2015 оны 3 дугаар улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэх” гэж тус тус заасны дагуу 173 хувьцаат компани санхүүгийн тайлангаа ирүүлжээ.

Дээрх компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 4,221.5 тэрбум төгрөг байгаагаас эргэлтийн хөрөнгө 33.47 хувь, эргэлтийн бус хөрөнгө 66.53 хувийг тус тус эзэлж байна. Пассивын хэсэгт богино хугацаат төлбөр 16.82 хувийг, урт хугацаат өр төлбөр 26.19 хувийг, эздийн өмчийн дүн 57.00 хувийг тус тус эзэлж байна.

Үнэт цаасны зах зээлийн тогтвортой байдлыг индексийн хэлбэлзлийн түвшингээр тооцох ба тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15,737.17 нэгж, доод үзүүлэлт 12,477.28 нэгж, дундаж үзүүлэлт 13,679.51 нэгж байв. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,668.71 нэгжээр буюу 16.89 хувиар буурч, 13,129.04 нэгж болжээ.

Дүрслэл20. Зах зээлийн үнэлгээ ба ТОП-20



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт нь 1057.86, доод үзүүлэлт нь 921.67, дундаж үзүүлэлт 971.20 нэгж байв. 2015 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 954.21 нэгжид хүрчээ.

Дүрслэл 21. MSE ALL индекс



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Шигтгээ 9:

Үнэт цаасны зах зээлийн индексүүдийн хөдөлгөөнөөс буурах хандлага ажиглагдаж байгаа бөгөөд 2005 оноос 2015 оны 9 дүгээр сар хүртэлх ТОП-20 индексийн тэгш хэмийн түвшинг эконометрикийн програм ашиглан тооцож үзвэл skewness шинжүүр 0.78, стандарт хазайлт 7391.9 нэгж байгаа нь үнэт цаасны зах зээлийн үнэ ханши хэт өндөр савалгаатай, үнэ ханшийн мэдээлэлд тулгуурлан тухайн хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад эрсдэлтэйг харуулж байна.

Үнэт цаасны зах зээлийн үр ашигтай, тогтвортой байдал мэдээллийн үр ашгийн хэлбэрт оршдог тул үр ашигтай зах зээлийн төсөөллийн (Efficiency market hypothesis) загварыг weak form efficiency хэлбэрийг ашиглан тооцдог ба 2005-2014 оны үнэт цаасны индексийн үзүүлэлтэд шинжилгээ хийж, математик, статистикийн аргаар хэмжихэд дараах дүгнэлт гарав.

Монгол Улсын үнэт цаасны зах зээл үр ашигтай зах зээлийн шинжийг агуулаагүй, өөрөөр хэлбэл үнэт цаасны зах зээл өнгөрсөн хугацааны индексийн өгөөж болон үнийн өөрчлөлтөнд агуулагдаж буй мэдээллээс хамааралгүй, зах зээл дэх дотоод мэдээлэл эзэмшигч, мэргэжлийн оролцогч байгууллагын шууд оролцоо буюу үгсэн тохиролцох замаар зохиомлоор үнэ ханши тогтох, энэ нь эргээд үнэт цаасны индекс нөлөөлөх эрсдэл өндөр буйг харуулсан. Тиймээс цаашид үнэт цаасны арилжааны хяналтыг сайжруулах, дотоод мэдээлэл эзэмшин арилжаанд оролцох, үнэ ханшийг өсгөх бууруулах үйлдлийг таслан зогсоох хатуу зохицуулалтын орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

Төрийн зохицуулалт, хяналтын орчин: Олон улсын үнэт цаасны зохицуулах байгууллагуудын холбоо буюу IOSCO-оос өөрийн гишүүн байгууллагуудад хөрөнгө оруулагчдын эрх ашгийг

хамгаалах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ил тод, шударга, тогтвортой зах зээлийг бий болгоход өөрийн зохицуулалт, хяналтыг голчлон чиглүүлэхийг зөвлөсөн.

Шигтгээ 10:

2008 оны дэлхийн санхүүгийн зах зээлийн хямралаас хойших хугацаанд улс орнууд дахин санхүүгийн хямрал давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн тогтолцоог бэхжүүлэх, дэд бүтцийг шинэчлэх шаардлагатай тулгарсан бөгөөд G20 орнуудаас байгуулсан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс шинэчлэлийг 4 үндсэн салбарт эрчимжүүлэхийг зөвлөжээ. Үүнд:

- Үр ашигтай, уян хатан санхүүгийн институтуудыг бий болгох;*
- ОТС буюу биржийн бус зах зээл дээрх үүсмэл үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоонд төрийн зохицуулах байгууллагаас хяналт тавих, оролцогчдод тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх;*
- Үндэстэн дамнасан томоохон санхүүгийн байгууллагуудыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, тэдгээр хяналт тавих;*
- Банкнаас бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч институтуудын үйл ажиллагааг хянах.*

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс дээрх шинэчлэлийг эрчимжүүлэх чиглэлээр үнэт цаас, даатгал, банкны төрийн зохицуулалтын хяналтын ОУ-ын байгууллагууд болох IOSCO, IAIS, Basel-ийн хороодтой хамтран ажиллаж байгаа ба шинэчлэлийг хэрэгжүүлэхэд төрийн зохицуулах байгууллагуудын өмнө зарим асуудлууд тулгарч байна. Үүнд:

Хил дамнасан гүйлгээ, шилжүүлэг нь гэмт хэргийн шинжийг агуулан үнэ хани өсгөх, бууруулах зорилготой хийгдсэн тохиолдолд зохицуулалтын байгууллагын зүгээс хяналт, шалгалт хийхэд хууль тогтоомжийн ялгаа хүндрэл учруулдаг. Иймд зохицуулах байгууллагуудын хооронд хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөтгөх, мэдээлэл солилцох ажиллагааг хөнгөвчлөх, өргөжүүлэх болсон.

Зарим хөгжиж буй зах зээлтэй орнуудад санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын уялдаа холбоо сул, оролцогчдын тоо цөөн, бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж бага байгаа байдал нь салбарын эрсдэл зарим нэг салбарт төвлөрөх үндсэн шалтгаан болж байна.

Санхүүгийн зах зээл нь бүтээгдэхүүн үйлчилгээ, санхүүжилтийн хугацаанаас хамааран ялгаатай төрлүүдэд хуваагдаг боловч банк, санхүүгийн томоохон байгууллага болох санхүүгийн нэгдлүүд нь аль ч төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг цогц байдлаар харилцагч, хөрөнгө оруулагчдад хүргэж байна. Ингэснээр Basel-ийн хорооноос банкуудад тавигдах зохистой харьцаа болон бусад заавар, зөвлөмжийг боловсруулан гишүүн байгууллагууддаа мөрдөхийг зөвлөдөг бол IOSCO-оос үнэт цаасны зах зээлд оролцогчид, IAIS-оос даатгалын зах зээлд оролцогчдод тавигдах зөвлөмж, зааврыг тус тус хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна. Гэвч зохицуулах байгууллагуудын зүгээс дээрх зөвлөмж, заавруудыг хооронд нь хэрхэн дэс дараатайгаар уялдуулж хэрэгжүүлэхэд зарим хүндрэл тулгарч байна.

Манай орны хувьд санхүүгийн үйлчилгээнүүдийг цогц байдлаар хүргэдэг санхүүгийн нэгдлийн хэлбэртэй аж ахуйн нэгжүүд нэгэнт бий болоод байгаа бөгөөд санхүүгийн дэвшилтэд технологүүдыг ашиглан гадаадын аль ч орноос үнэт цаасны арилжаанд оролцох боломжтой болоод байна. Тиймээс үнэт цаасны зах зээлд үүсэн бий болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг даван туулах чиглэлээр эрсдэлд суурилсан газар дээрх болон зайны хяналт шалгалтын тогтолцоонд шилжих, зах зээлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн үнэт цаасны зах зээлийн хяналт, шалгалтын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, хувьцаат компаниудын

засаглал, мэдээллийн ил тод байдлыг хангах, өөрийгөө зохицуулах байгууллагуудыг хөгжүүлэх, хөрөнгө оруулагч, хэрэглэгчийг хамгаалах санг байгуулах шаардлага үүсч байна.

2011 оноос банк, түүнийн охин, хараат компаниуд Банкны тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын үйлчилгээний тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авч, үнэт цаасны зах зээлд үзүүлэх үйлчилгээг эрчимжүүлж, түүний хүрээг өргөжүүлж байна.

3.5 Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж” ТӨХК нь 2015 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 403.9 тэрбум төгрөгийн арилжааг хийсэн байна.


2015 оны эхнээс 3 дугаар улирлын эцсийн байдлаар нийт 146 удаагийн арилжаа зохион байгуулж 1,876 хэлцлээр 6,611 тонн ноолуур, 7,714 тонн хонины ноос, 369 тонн тэмээний ноос, 914 тонн ямааны завод ноос, 700 тонн хонины завод ноос, 19 тонн тэмээний завод ноос, 1,576 тонн хүнсний буудайг тус тус арилжиж, нийт 403.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Хүснэгт 8. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжаа

№	Арилжаалагдсан бараа, түүхий эд	хэмжээ /тонн /	Үнийн дүн /тэрбум төгрөг/
1	Ноолуур	6,611	367,9
2	Хонины ноос	7,714	13,4
3	Тэмээний ноос	369	2,0
4	Ямааны завод ноос	914	18,9
5	Хонины завод ноос	700	0,84
6	Тэмээний завод ноос	19	0,05
7	Хүнсний буудай	1,576	0,87
	Нийт	17,903	403,9

Эх сурвалж: “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж” ХК

Дүрслэл 22. Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны дүнд эзлэх хувь




Эх сурвалж: “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж” ХК

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Тус бирж нь 2015 оны 3 дугаар улирлын байдлаар шууд арилжих /spot/ гэрээгээр бараа, түүхий эдийн арилжааг явуулсан бөгөөд тайлант хугацаан дахь биржийн нийт арилжааны хэмжээг өмнөх оны мөн үедтэй харьцуулан дараах дүрслэлээр харуулав.

Дүрслэл 23.ХАА-н биржийн арилжаа



Эх сурвалж: “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж” ХК

ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн нийт арилжааг 2014 оны мөн үетэй харьцуулахад 22.04 хувиар буурчээ. Энэ нь манай орны нийт нутгаар өвөлжилт дулаахан байсантай холбоотойгоор голлох бараа бүтээгдэхүүн болох ноолуурын ургац муу, ширхэг богино, нэгжээс гарах түүхий эдийн хэмжээ бага байсан нь зах зээлийн үнэ ханш доогуур тогтоход нөлөөлсөн байна. Иймд түүхий эдийн чанар, бэлтгэлийн хэмжээ нийт арилжааны хэмжээнд нөлөөлсөн гэсэн дүгнэлт өгч болохоор байна.

Харин 2015 оны хавраас эхэлж тус биржээр хүнсний буудай арилжаалж эхэлсэн ба 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ургац хураалт бүрэн дуусч, арилжаа идэвхжээгүй байв. Намрын ургац хураалт бүрэн дуусч худалдан авалтууд хийгдэж эхлэх үе буюу 2015 оны 4 дүгээр улиралд хүнсний буудайн арилжаа идэвхжиж, тэр хэмжээгээр тус биржийн арилжааны хэмжээ нэмэгдэх эерэг хүлээлт байна. Цаашид биржээр арилжаалагдах бараа, түүхий эдийн төрлийг олшруулах шаардлагатай.


БҮЛЭГ 4. ДААТГАЛЫН САЛБАРЫНТОЙМ

4.1 Салбарын гүнзгийрэлт буюу эдийн засагт үзүүлэх нөлөө

Даатгалын салбарын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хураамжийн орлого болон нийт активын хэмжээгээр тооцдог бөгөөд 2015 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын салбарт үйл ажиллага явуулж буй даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 169.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 25.5 хувь буюу 34.5 тэрбум төгрөгөөр өссөн бол 2015 оны 2 дугаар улиралтай харьцуулахад даруй 1.01 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Дээрх үзүүлэлт өмнөх оны мөн үеийнхээс өсөхөд, Хөдөө аж ахуйн давхар даатгалын компанийг үүсгэн байгуулагдсантай холбоотой бол тухайн оны өмнөх улирлаас буурахад ердийн даатгалын компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгө 1 хувиар буюу 0.75 тэрбум төгрөгөөр өсч, хуримтлагдсан ашиг 35 хувь буюу 1.55 тэрбум төгрөгөөр, давхар даатгалын өглөг 51 хувиар буюу 2.09 тэрбум төгрөгөөр тус тус буурсан. Харин урт хугацаат даатгалын компанийн нийт хөрөнгө тайлант улиралд 0.18 тэрбум төгрөгөөр буюу 2.7 хувиар өсөж, үүнээс давхар даатгалын өглөг 2.6 дахин буюу 0.017 тэрбум төгрөгөөр, тайлант үеийн хуримтлагдсан ашиг 68.9 хувь буюу 0.067 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн боловч нийт дүнгээрээ буурсан тул ийнхүү нөлөөлжээ.


Дүрслэл 24. Даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын компаниудын хөрөнгийг салбарын бүтцээр авч үзвэл нийт хөрөнгийн 81 хувийг ердийн даатгал, 15 хувийг ХАА-н давхар даатгал, 4 хувийг урт хугацаат даатгалын компанийн актив хөрөнгө бүрдүүлж байна. Энэ оны өмнөх улирлаас нийт хөрөнгө өөрчлөлт ХАА-н давхар даатгал 4 хувиар, урт хугацаат даатгал 2.7 хувиар өссөн бол салбарын хэмжээнд ихэнх хувийг эзэлдэг ердийн даатгал 2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 25. Даатгалын салбарын нийт хөрөнгө /дэд бүтцээр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
	Ердийн даатгал		
1	Монгол даатгал	26.59	19%
2	Тэнгэр даатгал	12.09	9%
3	Бодь даатгал	11.54	8%
4	Миг даатгал	10.40	8%
5	Мандал женерал даатгал	9.63	7%
6	Соёмбо даатгал	9.13	7%
7	Практикал даатгал	8.96	7%
8	Ард даатгал	8.85	6%
9	Номин даатгал	8.29	6%
10	Хаан даатгал	6.24	5%
11	Монре даатгал	5.73	4%
12	Улаанбаатар хотын даатгал	5.61	4%
13	Ган зам даатгал	5.40	4%
14	Гэр даатгал	4.75	3%
15	Мөнх даатгал	4.27	3%
Нийт		137.48	100%
Урт хугацаат даатгал			
16	Нэшнл лайф даатгал	6,85	100%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ердийн даатгалын 15 компани 137.48 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй байгаагаас “Монгол даатгал” ХХК 19 хувь, “Тэнгэр даатгал” ХХК 9 хувь, “Бодь даатгал” ХХК 8 хувь, “Миг даатгал” ХХК нар 8 хувийг тус тус эзэлж байгаа бусад компаниуд үлдсэн 56 хувийг бүрдүүлжээ.

Хүснэгт 10. Даатгалын компаниудын хөрөнгийг балансын зүйлээр (хувиар)

№	Үзүүлэлт	Ердийн даатгал	Урт хугацаат даатгал	ХАА-н давхар даатгал
1	Эргэлтийн хөрөнгө	81%	61%	99%
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	51%	51%	32%
3	Богино хугацаат хөрөнгө оруулалт	16%	7%	58%
4	Хадгаламж	14%	0%	0%
5	Эргэлтийн бус хөрөнгө	19%	39%	1%
6	Өр төлбөр	51%	22%	28%
7	Нөөц сан	48%	22%	28%
8	Эзэмшигчдийн өмч	51%	78%	72%
9	Хувь нийлүүлсэн хөрөнгө	40%	66%	59%
10	Хуримтлагдсан ашиг	2%	-10%	10%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн 82.7 хувийг эргэлтийн хөрөнгө, 17.3 хувийг эргэлтийн бус хөрөнгө, эх үүсвэрийн 46.9 хувийг өр төлбөр, 53.1 хувийг эзэмшигчдийн өмч тус тус эзэлж байна.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Ердийн даатгалын компанийн эх үүсвэрийн 48 хувь буюу 65.3 тэрбум төгрөгийг нөөц сан бүрдүүлж байгаа бол нийт хөрөнгийн 58 хувь буюу 79.9 тэрбум төгрөгийг банкны хадгаламжид, 2 хувь буюу 2.3 тэрбум төгрөгийг урт хугацаат хөрөнгө оруулалтад байршуулжээ.


Урт хугацааны даатгалын компанийн эх үүсвэрийн 22 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг нөөц сан бүрдүүлж байгаа бол нийт хөрөнгийн 49 хувийг буюу 3.4 тэрбум төгрөгийг банкны хадгаламжид хадгалуулжээ. Хөдөө аж ахуйн давхар даатгалын компани нөөц сангийн 7 тэрбум төгрөгийг банкны хадгаламжид, 14.7 тэрбум төгрөгийг богино хугацаат бусад хөрөнгө оруулалтад байршуулсан байна.

Нийт активыг ДНБ-д харьцуулсан байдал: Даатгалын салбарын эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийн тооцоолол 2015 оны 3 дугаар улирлын тоон мэдээлэл, Үндэсний статистикийн хорооноос гаргадаг ДНБ-ий оны үнээр тооцсон дүнд харьцуулахад 1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 11. Актив ба ДНБ-ийн харьцаа / Дүрслэл 26. Актив ба ДНБ-ийн харьцаа

	Актив ба ДНБ-ийн харьцаа			
	Урт хугацааны даатгал	Ердийн даатгал /ДНБ	ХАА-н давхар даатгал/ ДНБ	Даатгалын салбар
2011.III	0.04%	0.72%	-	0.75%
2012.III	0.03%	0.82%	-	0.85%
2013.III	0.04%	0.88%	-	0.91%
2014.III	0.04%	0.81%	-	0.84%
2015.III	0.04%	0.82%	0.15%	1.01%


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Хүснэгт 12. Нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь / Дүрслэл 27. Хураамжийн орлого/ДНБ ДНБ-д эзлэх хувь

	Даатгалын гүнзгийрэлт	Урт хугацааны даатгалын гүнзгийрэлт	Ердийн даатгалын гүнзгийрэлт
2011.III	0.38%	0.0024%	0.38%
2012.III	0.50%	0.0036%	0.50%
2013.III	0.50%	0.0051%	0.50%
2014.III	0.51%	0.0043%	0.50%
2015.III	0.53%	0.0078%	0.52%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Шигтгээ 11:

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Даатгалын салбарын гүнзгийрэлтийн тооцооллоор даатгалын салбарын нийт актив ДНБ-ий 1.01 хувийг эзэлж байгаа нь тухайн салбарын эдийн засаг, санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөөлөл сул байгааг илтгэж байна. Тиймээс даатгалын салбарын эдийн засаг, санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, урт хугацааны даатгалын салбарыг хөгжүүлэх шаардлагатай тулгарч байна.

Даатгалын салбар нь нийгэм, эдийн засгийн тогтолцоонд үндсэн хоёр чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хувь хүн, аж ахуйн нэгжүүдийн ирээдүйд бий болох хүлээгдээгүй алдагдлаас урьдчилан сэргийлэхийн тулд даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд хохирлыг барагдуулах;
- Нөөц сангуудаар дамжуулан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлснээр санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг давхар хангах.

4.2 Даатгалын салбарын үйлчилгээний хүртээмж

2015 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 1, ХАА-н давхар даатгалын 1 компани, нийт 3372 даатгалын мэргэжлийн оролцогч уг зах зээлд оролцож байгаагаас 34 зуучлагч, 24 хохирол үнэлэгч, 3314 төлөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлөөс харахад, ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд даатгуулагчдад нийт 17 төрлийн ердийн, 6 төрлийн урт хугацааны бүтээгдэхүүнийг хүргэж байгаа бөгөөд 2015 оны 3 дугаар улирлын байдлаарх даатгалын хураамжийн орлогыг бүтээгдэхүүн бүрээр задалж үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 13. Даатгалын хураамжийн орлого /бүтээгдэхүүнээр/

№	Бүтээгдэхүүний хэлбэр	Даатгалын нийт хураамжийн орлого /тэрбум төгрөг/	Эзлэх хувь	Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	Эзлэх хувь
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	8.5	10%	2.76	10.19%
2	Хөрөнгийн даатгал	20.9	24%	1.85	6.83%
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	11.9	14%	6.62	24.42%
4	Ачааны даатгал	1.1	1%	0.21	0.78%
5	Барилга угсралтын даатгал	0.4	1%	1.54	5.67%
6	Газар тариалангийн даатгал	0.00	0%	0.00	0.00%
7	Мал амьтдын даатгал	0.5	1%	0.05	0.17%
8	Агаарын хөлгийн даатгал	2.8	3%	0.00	0.00%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	0.3	0%	0.02	0.08%
10	Хариуцлагын даатгал	4.8	5%	0.25	0.92%
11	Санхүүгийн даатгал	2.7	3%	1.19	4.39%
12	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	18.0	21%	10.59	39.07%
13	Зээлийн даатгал	0.6	1%	2.01	7.42%
14	Итгэлцлийн даатгал	0.01	0%	0.01	0.02%
15	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	0.00	0%	0.00	0.00%
16	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	0.00	0%	0.00	0.00%

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

17	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	15.2		17%	0.01	0.04%
Ердийн даатгалын бүтээгдэхүүний дүн		87.8		100%	9.5	100%
1	Хугацаат амьдралын даатгал	0.3		21%	0.08	12%
2	Насан туршийн даатгал	0.00		0%	0.00	0%
3	Хуримтлалын даатгал	0.06		5%	0.07	10%
4	Тэтгэврийн даатгал	0.04		3%	0.03	4%
5	Эрүүл мэндийн даатгал	0.9		71%	0.05	74%
6	Аннуити даатгал	0.00		0%	0.00	0%
Урт хугацаат даатгалын бүтээгдэхүүний дүн		1.3		100%	0.7	100%
Нийт		89.1		-	27.8	-

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2015 оны 3 дугаар улирлын өссөн дүнгээр хураамжийн орлогыг бүтээгдэхүүний төрлөөр задалвал ердийн даатгалын 12 төрлийн бүтээгдэхүүнээс нийт орлогын 98.5 хувийг буюу 87.8 тэрбум төгрөгийг, урт хугацаат даатгалын 4 төрлийн бүтээгдэхүүнээс 1.3 тэрбум төгрөг буюу 1.5 хувийг тус тус даатгалын компаниуд бүрдүүлжээ.

Ердийн даатгалын бүтээгдэхүүний орлогын 24 хувийг хөрөнгийн, 21 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын, 17 хувийг агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, 14 хувийг авто тээврийн хэрэгслийн, 10 хувийг гэнэтийн осол, эмчилгээний зардлындаатгал тус тус эзэлж, нийт 5 төрлийн бүтээгдэхүүнээс хураамжийн орлогын 86 хувийг төвлөрүүлжээ. Харин урт хугацаат даатгалын бүтээгдэхүүний орлогын 71 хувийг эрүүл мэндийн, 21 хувийг хугацаат амьдралын даатгалаас буюу 2 төрлийн бүтээгдэхүүнээс хураамжийн орлогын 92 хувийг бүрдүүлсэн байна.


Тайлант хугацаанд даатгалын салбарын орлого бүрдүүлэлтийн 52 хувийг даатгалын төлөөлөгч, 32 хувийг даатгалын компани, 16 хувийг 34 даатгалын зуучлагч компаниуд бүрдүүлэв. Олон улсын түвшинд даатгалын салбарын хүртээмжийг хэмжихэд даатгалын нягтралын үзүүлэлтээр тооцдог бөгөөд 2014 оны жилийн эцсийн өгөгдөлд тулгуурласан тооцооллыг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Хүснэгт 14. Даатгалын нягтрал

	Нягтрал (Хураамжийн орлого/хүн ам)	Өсөлт %	Хураамжийн орлого (төгрөг)	Хүн амын тоо	Хураамжийн орлогын өсөлт %	Хүн амын тооны өсөлт %
2010	8 627.41		23 820 000 000.00	2 760 968	-	-
2011	13 004.42	51	36 564 094 895.42	2 811 666	54	2
2012	20 045.70	54	57 485 930 433.12	2 867 744	57	2
2013	22 900.18	14	67 103 867 873.22	2 930 277	17	2
2014	24 681.16	8	73 943 509 753.95	2 995 949	10	2

Дүрслэл 28. Даатгалын нягтрал

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Шигтгээ 12:


2014 оны жилийн эцсийн байдлаар нэг хүнд 24,681.16 төгрөгийн даатгалын хураамжийн орлого ногдож байна. Цаашид нэг хүнд ногдох хураамжийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр урт хугацааны даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, ердийн даатгалын бүтээгдэхүүний хүртээмжийг дээшлүүлэх, бичил даатгал болон албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг төрийн бодлогоор дэмжих шаардлагатай.

Олон улсын даатгалын салбарын хөгжлийн чиг хандлагаас харахад, төрийн зохицуулах байгууллагын зохицуулалтын бодлогын зорилго нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахын тулд ил тод, тогтвортой, тунгалаг зах зээлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа тул даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийг үндсэн чиглэлээ болгож байна.

Мөн олонх улс орнуудад хүртээмжтэй даатгалын салбарыг хөгжүүлэх чиглэлээр төрийн зохицуулалт, хяналтын байгууллагуудаас өөрийн нөхцөл байдалд тохирсон бодлого, зохицуулалтын олон аргыг хэрэглэж байх бөгөөд өнөөгийн байдлаар олон улсын түвшинд нийтлэг 5 төрлийн зохицуулалтын хандлагын загвар давамгайлж байна. Эдгээр зохицуулалтын хандлага, загварууд нь өөр өөрийн давуу болон сул талуудтай бөгөөд тухайн улс нь даатгалын салбарын нөхцөл, байдал, хөгжлийн бодлогод нийцүүлэн холимог болон ганцаарчилсан байдлаар хэрэгжүүлж байна.

Хүртээмжтэй даатгалын төрийн зохицуулалтын хандлага нь эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хөгжлийн нэгдсэн бодлого болон хүртээмжтэй даатгалын хөгжлийн бодлогын үндсэн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх 4 хэрэгслийг агуулж байна.

Зураг 2. Хүртээмжтэй даатгалын бодлогын дамжуулах механизм



Манай орны хувьд хүртээмжтэй даатгалын урт хугацааны зах зээлийн хөгжлийн хандлагыг /long term market development approach/ баримталдаг бөгөөд уг хандлагыг хөгжиж буй орнуудын бага орлоготой иргэдэд чиглэсэн хүртээмжийн бодлогыг хэрэгжүүлэхэд түлхүү ашигладаг.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Манай оронд иргэд, аж ахуйн нэгжүүд сайн дурын даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгон хэрэглэхээс илүүтэйгээр холбогдох хууль тогтоомжоор үүрэг болгосон албан журмын даатгалд хамрагдах хамралт өндөр байна. Тиймээс даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нийгмийн бүлгүүдэд чиглэсэн, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр санал болгох чиглэлээр албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх талаар хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

4.3 Даатгалын салбарын үр ашигт байдал

2015 оны 3 дугаар улирлын байдлаар даатгалын компаниудын ашигт ажиллагааг тооцоход, нийт хөрөнгийн өгөөжийн дүн салбарын хэмжээнд 37 хувь, үүнээс урт хугацаат даатгалын компанийн өгөөжийн дүн 19 хувь, ердийн даатгалын компани 38 хувьтай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 5 хувиар буурч, 2015 оны 2 дугаар улирлын дүнгээс 10 хувиар өссөн үзүүлэлттэй байв.

Харин өөрийн хөрөнгийн өгөөжийн салбарын дундаж 74 хувь байгаа бөгөөд үүнээс урт хугацаат даатгалын өөрийн хөрөнгийн өгөөжийн дүн 24 хувь, ердийн даатгал 78 хувьтай гарсан нь өмнөх оны мөн үеийнхээс 17 хувиар буурч, 2015 оны 2 дугаар улирлын дүнгээс 20 хувиар өссөв.

Хүснэгт 15. Ашигт ажиллагаа

	Нийт хөрөнгийн өгөөж			Өөрийн хөрөнгийн өгөөж		
	Урт хугацаат даатгал	Ердийн даатгал	Даатгалын салбар	Урт хугацааны даатгал	Ердийн даатгал	Даатгалын салбар
2011.III	5%	40%	38%	6%	93%	84%
2012.III	12%	44%	43%	14%	92%	87%
2013.III	13%	41%	40%	16%	93%	88%
2014.III	17%	43%	42%	21%	96%	91%
2015.II	12%	27%	27%	15%	57%	54%
2015.III	19%	38%	37%	24%	78%	74%

Дүрслэл 29. Ашигт ажиллагаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ердийн даатгалын компанийн хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 7.26 тэрбум төгрөгөөр буюу 9 хувиар, татварын дараах цэвэр ашиг 0.65 тэрбум төгрөгөөр буюу 68 хувиар өссөн байна. Урт хугацаат даатгалын компанийн хураамжийн орлого 0.29 тэрбум төгрөг буюу 29 хувиар, татварын дараах цэвэр ашиг 0.11 тэрбум төгрөг буюу 1.7 дахин тус тус өсчээ.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

2015 оны 3 дугаар улиралд ердийн даатгалын компанийн олгосон нөхөн төлбөрийн хэмжээ хураамжийн орлогын 10.8 хувь, урт хугацаат даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ хураамжийн орлогын 53 хувийг тус тус эзэлж байгаа бол даатгалын салбарын хэмжээнд нийт нөхөн төлбөрийн хэмжээ хураамжийн орлогын 11.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 16. Даатгуулагч болон нөхөн төлбөр авсан тоо

	Даатгуулагчийн тоо			Нөхөн төлбөр авсан		
	Хувь хүн	Хуулийн этгээд	Нийт	Хувь хүн	Хуулийн этгээд	Нийт
2010.III	431,443	11,629	443,072	9,315	6,890	16,204
2011.III	681,004	20,804	701,808	8,916	7,736	16,652
2012.III	696,421	48,724	745,145	9,608	9,526	19,134
2013.III	370,880	55,159	426,037	21,066	10,074	31,140
2014.III	735,563	94,262	829,812	29,199	12,986	42,185
2015.III	734,758	98,153	832,902	33,833	15,781	49,614

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын хэмжээнд ашигт ажиллагааны түвшин өндөр өсөлттэй гарахад “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн тайлант үеийн цэвэр ашиг гол нөлөөлөгч хүчин зүйл болсон бол урт хугацааны даатгалын компанийн цэвэр ашиг анх удаа өндөр өсөлттэй гарав.

Шигтгээ 13:

Даатгалын салбарын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын өрсөлдөөний төлөвийг тогтоох чиглэлээр хийгдэх ажлууд:

- Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нийгмийн бүлгүүдэд чиглэсэн, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хэлбэрээр санал болгох хүрээнд албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Салбарын мэргэжлийн холбоодын чадавхийг бэхжүүлж, тэдгээрийг өөрийгөө зохицуулах байгууллагын хэлбэрт шилжүүлэн төрийн хяналт, зохицуулалтын зарим чиг үүргийг олгох;
- Олон улсын даатгалын хяналт, зохицуулалтын хорооноос гаргасан зөвлөмжийг даган мөрдөж, хэрэгжүүлэх, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоонд шилжих, мэдээллийн нэгдсэн баазыг бий болгох, даатгагчийн нийт актив хөрөнгийг ангилан эрсдлийн болон тогтвортой байдлын сан байгуулахад шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэх.

4.4 Даатгалын салбарын тогтвортой байдал

2015 оны 3 дугаар улирлын байдлаар хураамжийн орлогоос гадаадын давхар даатгалын компанид төлж байгаа төлбөр 34.25 тэрбум төгрөг буюу нийт хураамжийн орлогын 38 хувийг эзэлсэн бол өмнөх 5 жилийн дундаж нь 27 хувьтай байв. Нийт давхар даатгалын төлбөрийн 99.94 хувийг ердийн даатгал, 0.06 хувийг урт хугацаат даатгалын компани шилжүүлсэн ба ердийн даатгалын компани хураамжийн орлогын 66 хувийг, урт хугацааны даатгалын компани 1.72 хувийг давхар даатгалд тус тус төлжээ.

Давхар даатгалын үндэсний компани байхгүй байгаа нь даатгалын салбар дахь гадаад валютын гадагшлах урсгалыг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болж, цаашид салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлал бий. Даатгалын салбар нь нийгэм, эдийн засагт учрах хүлээгдээгүй эрсдлийг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг хэдий ч даатгалын салбарын өөрийн тогтворгүй байдал, системийн эрсдлийн түвшин нь эргээд санхүүгийн тогтвортой байдалд томоохон нөлөө үзүүлдэг.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Манай орны арилжааны даатгалын салбар нь өнөөг хүртэл нийгмийн хамгааллын салбар дахь төрийн ачааллыг бууруулах чиглэлээр бэхжиж чадаагүй, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийн оновчтой бодлого хэрэгжээгүйгээс эдийн засаг, санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөөлөл сул байна.

Шигтгээ 14:

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /Financial stability board/ болон Олон улсын даатгалын хяналт, зохицуулалтын байгууллагуудын хороо /IAIS/-оос даатгалын салбарт учирч буй системийн эрсдэлийг үндсэн гурван чиглэлийн хүрээнд тодорхойлжээ. Үүнд:

- *санхүүгийн зах зээлийн бусад оролцогчдоос /банк, үнэт цаасны компаниуд/ үүдэлтэй эрсдлийн нөлөөлөл;*
- *даатгалын компани уг нөлөөлөлд хариу үйлдэл үзүүлснээр эрсдэл бууруулах чадвар;*
- *даатгалын компани нь өөрөө системийн эрсдлийг үүсгэгч.*

Олон улсын даатгалын зах зээлийн үйл ажиллагаа бүс нутгийн болон олон улсын түвшинд өргөжиж, үндэстэн дамнасан шинжтэй болж байна. Олон улсын даатгалын хяналт, зохицуулалтын байгууллагуудын холбоо /IAIS/-оос хойд Америкийн болон Евро бүсийн даатгалын салбар нь дэлхийн даатгалын салбарын 65 хувийг эзэлж байна гэсэн судалгаа хийсэн ба дээрх хувь хэмжээ цаашид буурах хандлагатай байгааг онцолжээ. Учир нь Азийн болон өмнөд Америкийн бүс нутгуудад даатгалын салбар эрчимтэй хөгжиж, эдгээр бүс нутагт даатгалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгдэж байгаа аж.

2008 оны дэлхийн санхүүгийн зах зээлийн хямралаас хойших хугацаанд олон улсын хяналт, зохицуулалтын байгууллагуудаас улс орнуудад санхүүгийн тогтолцоогоо бэхжүүлэх, дэд бүтцээ шинэчлэхийг зөвлөж байна. Тухайлбал, олон улсын даатгалын хяналт, зохицуулалтын байгууллагуудын холбоо /IAIS/-оос өөрийн гишүүн зохицуулагч байгууллагуудад макро болон микро зохистой бодлогын хүрээнд хяналт, зохицуулалтын эрх зүйн орчноо шинэчлэх, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, системийн ач холбогдолтой даатгагчийг тодорхойлох, хянах шалгуурыг боловсруулах, санхүүгийн нэгдэл, үндэстэн дамнасан даатгалын компаниудад group supervision хяналтыг хэрэгжүүлэх зэргийг өөртөө агуулсан ICS 1.0 стандартыг 2016 оны сүүлээр нэвтрүүлж, хэрэгжүүлэхийг зөвлөж, улмаар 2018 оны сүүлээс ICS 2.0 стандартыг боловсруулахаар тогтсон.

БҮЛЭГ 5. БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ**А. Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)****5.1 Банк бус санхүүгийн салбарын гүнзгийрэлт буюу эдийн засагт үзүүлэх нөлөө**

Банк бус санхүүгийн салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг голчлон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх нийт активын болон олгосон зээлийн хэмжээгээр тооцдог. ББСБ-ын нийт активын хэмжээ сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд 2015 оны 3 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр 582.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 92 тэрбум төгрөг буюу 18.8 хувиар өссөн үзүүлэлттэй байв.

Нийт активын 562.5 тэрбум төгрөг буюу 96.69 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа ба үүний 65.8 хувийг зээл, 25.3 хувийг мөнгөн хөрөнгө тус тус эзэлж байна. Активын хэмжээ нэмэгдэхэд шинэ ББСБ-уудын тоо нэмэгдсэнээс гадна нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 30.4 хувиар өссөн нь голлогч нөлөөг үзүүлжээ.

Дүрслэл 30. ББСБ-ын нийт хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт активын ДНБ-д эзлэх хувь: 2015 оны 3 дугаар улирлын байдлаар ББСБ-ын нийт активын дүнг мөн улирлын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн дүнд харьцуулахад 3.5 хувийг эзлэв.

Зээлийн ДНБ-д эзлэх хувь: Тайлант хугацаанд зээлийн багц нийт активын 65.8 хувь буюу 383.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 89.4 тэрбум төгрөг буюу 30.4 хувиар өссөн. Дээрх зээлийн багцын өсөлтөд хугацаа хэтэрсэн зээл 14.7, хэвийн зээл 27.06, чанаргүй зээл 95.6 хувиар тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Чанаргүй зээл нийт зээлийн харьцаа 9.1 хувьтай гарсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар өссөн. Мөн чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 95.6 хувиар өссөн, цаашид ч өсөх хандлага харагдаж байна. Иймд эдийн засгийн өсөлт саарснаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагын орлого буурч буй өнөөгийн нөхцөлд хэт их хэмжээгээр өндөр хүүтэй зээл олгох нь уг салбар дахь зээлийн эрсдэлийн хэмжээг нэмэгдүүлж болзошгүй.



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2015 оны 3 дугаар улирлын байдлаар ББСБ-ын нийт олгосон зээлийн дүнг мөн улирлын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн дүнд харьцуулахад 2.3 хувийг эзэлж байна.

Шигтгээ 15:

Олон улсын санхүүгийн зах зээлд 40-өөд жилийн өмнө бичил санхүүгийн үйлчилгээ үүссэн бөгөөд өнгөрсөн хугацаанд бичил санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ өргөжиж, дэлхий даяар олон тооны бичил санхүүгийн байгууллагууд үйлчилгээгээ тэлж, хэдэн зуун сая харилцагчидтай болоод байна.

Бичил санхүүгийн салбар нь бичил бизнес, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон барьцаа хөрөнгөгүй иргэдэд чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж байгаа нь эргээд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх үндсэн хэрэгсэл болдог. НҮБ-аас 2015 оны 9-р сарын 25-нд баталсан “Шинэ тогтвортой хөгжлийн зорилго”-ын нэг хэсэг нь хариуцлагатай, шударга санхүүгийн үйлчилгээ бөгөөд дэлхий нийтээр ядуурлыг 2030 он гэхэд дорвитой багасгах урьдчилсан нөхцөл болох юм. Учир нь бичил санхүүгийн байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээ бичил болон ЖДҮ-ийн хөгжил, түүний санхүүжилттэй холбоотой.

Аливаа улсын хувьд ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулж, орлогын тэгш бус хуваарилалтыг багасган нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлж, хувийн секторын хөгжлийг хангахад онцгой хувь нэмэртэй. Азийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн онцлог шинжийг дурдвал:

- Азийн орнуудын эдийн засгийн өсөлт нь жижиг, дунд үйлдвэрлэлээс хамааралтай тул тэдгээрийн хэрэгцээг хангах жижиг зээллэг, санхүүжилт ихээхэн шаардлагатай;
- Томоохон дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай, үнэт цаас, бондын зах зээл сайн хөгжжөөгүй;
- Банк төвтэй санхүүгийн систем давамгайлсан, банк бус санхүүгийн салбар хөгжлийнхөө эхний шатанд байна.

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөгжлийг эрчимжүүлэхэд бүс нутгийн хамтын ажиллагаа чухал бөгөөд Азийн бүс нутгийн интеграцийн гол төлөөлөл бол “Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, мөнгөн төлбөр тооцоо, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх” зорилго бүхий ASEAN+3. Иймд бичил санхүүгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр бүс нутгийн интеграцид нэгдэх нь идэвх санаачлагатай оролцох шаардлага тулгараад байна.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм


ББСБ-ын нийт актив болон олгосон зээлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ бага байгааг харгалзан цаашид тэдгээрийн санхүүгийн чадавхийг сайжруулан эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх үүднээс үнэт цаасны зах зээлд хувьцаа, хоёрдогч өглөгөөр дамжуулан нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргах хэлбэрээр олон нийтээс хөрөнгө татахыг дэмжихэд төрийн зохицуулалтыг чиглүүлэх нь зүйтэй.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас ЖДҮ-ийг хөгжүүлэх, тэдгээрийн санхүүжилтийг үнэт цаасны зах зээлээс босгох чиглэлээр санхүүгийн технологийн шинэлэг хэлбэрүүд /crowdfunding, peer to peer lending/-ийг хөгжүүлэхийг зөвлөмж болгон гаргасан. Азийн хөгжиж буй орнуудын хувьд инновацийн чиглэлээр жижиг бизнес эрхлэгчдийн хувьд эхлэлтийн санхүүжилт босгох асуудал хамгийн том бэрхшээл тул банк бус санхүүгийн салбарын тусламжтайгаар үүнийг шийдвэрлэх боломж бий.

5.2 Банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээний хүртээмж, олон улсын хандлага

2015 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 442 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 32. Бүртгэлтэй ББСБ-ын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үеийнхээс 91 буюу 26 хувиар нэмэгдэв. Энэ нь нийт санхүүгийн систем дэх чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан арилжааны банкуудаас тавигдах зээлийн нөхцөл чангарч, иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчид болон аж ахуйн нэгж байгууллагууд шаардлагатай зээлийн санхүүжилтийг банк бус санхүүгийн байгууллагуудаас авах тохиолдол улам ихэссэн. Нөгөөтэйгүүр, макро эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, эдийн засгийн өсөлт удааширч байгаа өнөөгийн нөхцөлд арилжааны банкуудын жилийн дундаж хүүгээс өндөр хүүтэй зээлийг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад олгож байгаа нь эргээд тэдэнд дарамт учруулж, зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөхгүй байх, улмаар чанаргүй зээлийн хэмжээг өсгөж байна.

Эрсдэл даах, өрсөлдөх чадвар бүхий үйл ажиллагаа нь жигдэрсэн, мэргэжлийн боловсон хүчинтэй санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, бичил зээлийн хүртээмжийг нэмэгдүүлснээр салбарын тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд Хорооноос эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 17. ББСБ-уудын статистикийн голлох үзүүлэлтүүд

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014Q3	2015Q3
1	ББСБ-ын тоо	351	442
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	863	901
3	Ажиллагсадын тоо	1632	1950
4	Салбар нэгжийн тоо	92	99
5	Харилцагчдын тоо	518,489	554,901
6	Нийт актив	490	582
	Банкны салбарт эзлэх хувь	2.7	3.0
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	294	383.3
	Банкны салбарт эзлэх хувь	2.0	3.3
8	Нийт эзэмшигчдийн өмч	301	393
	Банкны салбарт эзлэх хувь	24.9	15.8
9	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	25	32
10	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл	128	125
	Үүнээс: Богино хугацаат зээл	72.1	62
	Урт хугацаат зээл	55.7	63
11	Төслийн зээлийн санхүүжилт	12	14
12	Нийт орлого	99.3	115.4
13	Нийт зардал	72.4	82.3
14	Тайлант үеийн ашиг	26.7	33.3

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хүснэгт 18. ББСБ-ын үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрөл

Д / д	Үйл ажиллагааны нэр төрөл	2014Q3	2015Q3
1	Зээл	296	380
2	Гадаад валютын арилжаа	124	132
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	53	52
3	Итгэлцлийн үйлчилгээ	25	26
4	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх	27	26
5	Факторингийн үйлчилгээ	16	17
6	Төлбөрийн баталгаа гаргах	11	13
7	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	6
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт	2	2
9	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт ББСБ-ын 86 хувь буюу 380 компани зээлийн үйл ажиллагаа, 5.9 хувь буюу 26 компани хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, 5.9 хувь буюу 26 компани итгэлцлийн үйлчилгээ, 4.0 хувь буюу 17 компани факторингийн үйлчилгээ, 3.0 хувь буюу 13 компани төлбөрийн баталгаа гаргах, 1.4 хувь буюу 6 компани цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 0.5 хувь буюу 2 компани богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхэлж байна.

Хүснэгт 10-аас харахад, нийт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ууд зээлийн үйлчилгээг түлхүү үзүүлж байгаа ба цаашид санхүүгийн зөвлөгөө мэдээлэл өгөх, факторинг, төлбөрийн баталгаа гаргах, цахим төлбөр тооцооны үйлчилгээ, итгэлцэл, лизинг, батлан даалт бүхий зээлийн

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

үйлчилгээг өргөжүүлэх, алслагдсан дүүрэг, орон нутаг дахь ББСБ-ийн салбарын тоог нэмэгдүүлснээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрлийг олшруулах, улс орны санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх боломж бүрдэнэ.

Шигтгээ 16:

Банк төвтэй санхүүгийн тогтолцоотой орнуудад орлого багатай, барьцаа хөрөнгөгүй иргэд, жижиг бизнес, ЖДҮ-үүдийн санхүүжилтийн асуудал хүндрэлтэй байдаг. Тиймээс тэдгээрийн санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр ББСБ-ын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

Төрийн бодлого, зохицуулалтын зорилт нь санхүүгийн хүртээмж, зах зээлийн үр ашгийг дээшлүүлэх болон системийн тогтвортой байдлыг хангах гэсэн хувилбаруудыг оновчтой уялдуулах бөгөөд 2008 оны санхүүгийн хямралын дараагаас хөгжингүй эдийн засагтай орнууд тогтворжилтийн бодлогыг түлхүү баримталж байна. Харин банк давамгайлсан тогтолцоотой манай орны хувьд бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар өсөлтийг түргэтгэх бодлогыг хэрэгжүүлэх нь оновчтой.

5.3 Банк бус санхүүгийн салбарын үр ашигт байдал

2015 оны 3 дугаар улирлын байдлаар 442 ББСБ-уудын хөрөнгийн эх үүсвэр 582 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 92 тэрбум төгрөгөөр буюу 18.8 хувиар өсчээ.

Тайлант хугацаанд ББСБ-ын нийт эх үүсвэрийн 32.45 хувийг өр төлбөр, эзэмшигчдийн өмч 67.55 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 0.05 хувиар, эзэмшигчдийн өмч 30.4 хувиар тус тус өсчээ. ББСБ-уудын өөрийн хөрөнгө нэмэгдэхэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол өссөнөөр шинээр тусгай зөвшөөрөл авсан компаниудын тоо ихэссэн нь голлох нөлөөг үзүүлсэн бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 63.9 тэрбум төгрөг буюу 27.2 хувиар өсөв.

Хүснэгт 19. ББСБ-ын санхүүгийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013	2014	2015Q3
Нийт актив	96.5	128.6	205.4	252.1	381.1	508.0	582
Нийт олгосон зээл	55.5	78.1	119.0	157.8	223.7	303.1	383.3
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	96.5	128.6	205.4	252.1	381.1	508.0	582
Нийт өр төлбөр	21.6	36.6	67.2	80.7	146.8	175.9	188.7
Эзэмшигчдийн өмч	74.8	92.0	138.2	171.3	234.3	332.1	393
Үүнээс:							
Хувьцаат катитал	66.4	80.0	116.5	137.9	183.7	258.2	298.2
Бусад өмч	0.5	0.5	3.2	7.6	7.2	7.2	9.3
Сангууд	1.1	1.1	1.1	0.1	0.2	0.3	0.3
Хуримтлагдсан ашиг/алдагдал	6.1	9.4	14.7	24.2	41.7	64.0	83.6
Хоёрдогч өглөг	0.8	0.9	2.7	1.6	1.6	2.4	1.4
Нийт орлого	26.6	30.1	46.3	70.5	106.6	132.9	115.4
Нийт зарлага	21.7	22.9	34.9	51.9	76.8	96.5	82.3
Татварын дараах цэвэр ашиг	4.9	7.1	11.4	18.6	29.8	36.4	33.1

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2015 оны 3 дугаар улирлын эцэст ББСБ-ууд нийт 33.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.47 тэрбум төгрөг буюу 24.2 хувиар

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

өссөн үзүүлэлттэй гарсан. Үүнд нийт хүүгийн орлого 74.12 хувь, хүүгийн бус орлого 24.71 хувиар тус тус өссөн нь гол нөлөөг үзүүлэв.

Нийт активын өгөөж /ROA/ болон өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ тус тус 5.07, 8.44 гарсан нь бусад санхүүгийн салбар /Банк, үнэт цаас, даатгал/-ын оролцогчдоос өндөр үзүүлэлттэй гарав. Он гарсаар эдийн засгийн өсөлт буурч байгаатай холбоотойгоор аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааны ашиг, орлого муудаж, чанаргүй зээлийн хувь хэмжээ өссөн, цаашид ч өсөх хандлагатайг харгалзан зээлийн нөхцөлд тавигдах арилжааны банкуудын шаардлага өндөрссөн нь эргээд банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлж байна. Үүнээс шалтгаалан нийт ББСБ-ын чанаргүй зээлийн хэмжээ өсч, тодорхой хэмжээний эрсдэлийг салбарын хэмжээнд бий болгоод байна.

Хүснэгт 20. Орлого, зарлага, ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)


Д/д	Үзүүлэлт	2015Q3
1	Нийт орлого	115.4
	Хүүгийн орлого	85.6
	Хүүгийн бус орлого	28.5
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1.3
2	Нийт зардал	82.3
	Хүүгийн зардал	11
	Хүүгийн бус зардал	55.6
	Болзошгүй эрсдэлийн зардал	10.6
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.648
3	Орлогын татварын зардал	4.3
4	Татварын дараах цэвэр ашиг	33.3

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд нийт орлого 115.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 16 тэрбум төгрөг буюу 16.19 хувиар өссөн бол нийт зардлын хэмжээ 82.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.8 тэрбум төгрөг буюу 13.63 хувиар мөн өсчээ.

Дээр дурдсанаар тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудын 86 хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ба сарын зээлийн хүүгийн дээд хэмжээ 8.0 хувь, хамгийн бага хүү 1.0 хувьтай байв. Тайлант хугацаанд ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулахад хүүгийн маржин сарын 2.0 хувьтай байна.

Дүрслэл 33. Зээлийн хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Шигтгээ 17:

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Зээлийн хүүгийн түвшин харьцангуй өндөр байгаа нь санхүүжилтийн хомсдолтой ЖДҮ-ийн хөгжил, ядуу болон бага орлоготой иргэдийн амьжиргаанд эерэгээр нөлөөлөх нөлөөг сулруулж байна. Нөгөө талаар санхүүгийн хүртээмжийг бууруулах, харилцагчийн эрх ашгийг хохироох нөхцөл бүрдээд байна.

Хүүгийн түвшинг бууруулахын тулд ББСБ хувьд юуны өмнө үйл ажиллагааны зардлын хяналтыг сайжруулах шаардлагатай. Мөн манай улсад бичил санхүүгийн салбар нь хөгжлийн шатанд, цаашид салбарын өсөлт тэлэх хандлагатайг харгалзан санхүүгийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, нийт эх үүвэрийн санхүүжилтийг төсөл хөтөлбөр, олон нийтээс санхүүгийн дэвшилтэт технологийг ашиглан хөрөнгө татах замаар нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулж, зээлийн хүүг бууруулах талаар олон улсын бичил санхүүгийн туршилагыг нэвтрүүлж, бичил санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээг тэлэх зохицуулалтын орчинг боловсронгуй болгох шаардлагатай.

5.4 Банк бус санхүүгийн салбарын тогтвортой байдал

2008 оны дэлхийн санхүүгийн зах зээлийн хямралаас үүдэлтэйгээр G20 орнууд 2009 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл /Financial Stability Board/-ийг байгуулсан бөгөөд тус байгууллагаас улс орнуудад санхүүгийн дэд бүтцийн тогтолцоог бэхжүүлэх, шинэчлэхийг зөвлөсөн.

Энэхүү шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр уян хатан санхүүгийн институт /resilient financial institutions/-ыг бий болгох, үндэстэн дамнасан санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн байгууллага /“too big to fail”/-ыг тодорхойлох шалгуурыг боловсруулах, түүний үйл ажиллагаанд нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх, лангууны арын үүсмэл хэрэгслийн зохицуулалтыг шинэчлэх /OTC derivatives reform/, сүүдрийн банкны тогтолцоо /shadow banking/-г төрийн зохицуулах байгууллагаас зохицуулж, хянахыг тусгайлан зөвлөөд байна.

Манай орны хувьд ББСБ, ХЗХ-ны бие даасан хуулиуд болон Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа тул олон улсад бий болоод байгаа дээрх эрсдлүүд харьцангуй бага байна. Гэвч бичил санхүү нь ядуурлыг бууруулах, бага орлоготой иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүгийн үйлчилгээг хямд өртөгөөр хүргэх үндсэн чиг үүрэг бүхий салбар тул системийн тогтвортой байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр ББСБ-ын үйл ажиллагааг төрөөс хэрэгжүүлж байгаа жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, хөтөлбөртэй уялдуулж, бага орлоготой иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, алслагдсан бүс нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх, орон нутаг дахь бичил санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх хийгээд харилцагчдын эрх ашгийг хамгаалсан тогтолцоог бүрдүүлэх, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага тулгараад байна.

Шигтгээ18:

Олон улсад ББСБ-ууд арилжааны банкнаас илүүтэйгээр бичил санхүүгийн үйлчилгээг олон нийтэд хүргэж буй төлөв байдлын хандлага давамгайлж байгаа боловч банкны салбартай харьцуулахад төрийн үр дүнтэй хяналт зохицуулалтын орчин уг салбарт бүрдээгүй аж. Тухайлбал, сүүдрийн банкны үйл ажиллагаа нь санхүүгийн зохицуулагч байгууллагуудын зохицуулалтын хүрээний гадуур байх тул Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс сүүдрийн банкны үйл ажиллагаа эрхлэгч этгээдүүдийн үйл ажиллагаанд төрийн зохицуулах байгууллагын хяналт, зохицуулалтыг оновчтой түвшинд хэрэгжүүлэхийг анхааруулж байна.

2007 оноос эхлэн сүүдрийн банкны салбар хурдацтай тэлж, 2008 оны санхүүгийн хямралаас шалтгаалан уг салбарын өсөлт удааширсан. Дэлхийн санхүүгийн хямрал нь ипотекийн зээлийн хямрал буюу арилжааны банкууд ипотекийн зээл их хэмжээгээр олгон түүнд

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

суурилсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасжуулалтыг хийж, улмаар зээлийн чанар муудах, үл хөдлөх хөрөнгийн үнэ унахтай холбоотойгоор зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэл бий болсноос үүдсэн. Гэтэл уг үнэт цаасжуулалтын үйл ажиллагаанд сүүдрийн банкны оролцоо өндөр байв.

Хямралаас хойш уг салбарын өсөлт тэлэх хандлагатай буюу 2014 оны байдлаар сүүдрийн банкны нийт хөрөнгө нь 70 их наяд ам.долларт хүрээд байгаа бол түүний дийлэнх хувийг АНУ болон Европын холбооны орнууд эзэлж байгаа хэдий ч уг механизм нь төрийн зохицуулалтаас гадуур, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, үйл ажиллагааны эрсдэл өндөр зэрэг сөрөг нөлөө нь урт хугацаандаа санхүүгийн системд эрсдэл үүсгэх аюултай гэж шинжээчид таамаглал дэвшүүлж байна.

ББСБ-ын зохистой харьцааны үзүүлэлт: Тус Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу зохистой харьцааны үзүүлэлтийг 2015 оны 3 дугаар улирлын байдлаар тооцоход дараах байдалтай байна.

Хүснэгт 21. Зохистой харьцааны үзүүлэлт

Үзүүлэлт	Шаардлагат түвшин	2015Q3
1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт		
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	10% <=	83.5
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	20% <=	84.4
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10% <=	69.5
2. Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт		
Нийт валютын хувьд	(-40%, 40%)	1.2
3. Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт		
Итгэлцлийн үйлчилгээний өглөг ба хувьцаат капиталын хувьцаа	80% >=	8.1
4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар		
Түргэн борлогдох актив, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа	8% <=	108
5. Үндсэн хөрөнгийн үзүүлэлт		
Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн ба нийт активын харьцаа	15% >=	1.6

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Жич: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцоход дараахь үзүүлэлтийг ашиглав.
Үүнд:

- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ: нийт өөрийн хөрөнгө 394 тэрбум төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 467.1 тэрбум төгрөг;
- Гадаад валютын эрсдэл: валютын дансны цэвэр зөрүү 11.6 тэрбум төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 45 тэрбумтөгрөг;
- Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт: итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 32 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 393.6 тэрбум төгрөг;
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар: нийт түргэн борлогдох актив 112.2 тэрбум төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 170 тэрбум төгрөг;
- Үндсэн хөрөнгийн үзүүлэлт: нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 3.1 тэрбум төгрөг, нийт актив 581.8 тэрбум төгрөг.

Тайлант хугацаанд нийт 442 ББСБ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллгаа явуулснаас тав ба түүнээс дээш зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, дөрвөн зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, гурван зохистой харьцааг хангаагүй 7 ББСБ, хоёр зохистой харьцааг хангаагүй

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм


28ББСБ, нэг зохистой харьцааг хангаагүй 54 ББСБ байв. Зохистой харьцааны үзүүлэлтийг нийт 349 ББСБ хангаж ажилласан нь нийт ББСБ-ын 79 хувийг эзэлж байна.

Б. Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)

5.5 ХЗХ-ны салбарын гүнзгийрэлт буюу эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө:

ХЗХ-ны эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх нийт активын дүн, олгосон зээл, хадгаламжийн хэмжээгээр тооцох боломжтой. ХЗХ-ны нийт активын хэмжээ 2015 оны 3 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр нийт активын хэмжээ 93.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.7 тэрбум төгрөг буюу 15.76 хувиар өсчээ.

Дүрслэл 34. Хадгаламж, зээлийн хоршоодын активын өөрчлөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Активын төвлөрлөөр нь ангилахад, томоохон буюу 1 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 12 ХЗХ-ны нийт актив 66.2 тэрбум төгрөг ба 11.3 мянган гишүүдтэй байв. Энэ нь нийт ХЗХ-дын активын 70.9 хувь, нийт гишүүдийн 30.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 22. ХЗХ-дын нийт актив

№	Активын хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт актив		Тоо		Байршил	
			Дүн /тэрбум төгрөг/	Хувь	Тоо	Хувь	УБ	Орон нутаг
1	10,000,000.0 дээш	1	30.4	32.55%	3,465	9.16%	1	-
2	1,000,000.0-10,000,000.0	11	35.8	38.37%	7,906	20.91%	9	2
3	500,000.0-1,000,000.0	7	4.7	5.09%	3,443	9.10%	3	4
4	100,000.0-500,000.0	106	17.1	18.30%	14,526	38.41%	79	27
5	50,000.0-100,000.0	46	3.5	3.81%	4,049	10.71%	27	19
6	10,000.0-50,000.0	53	1.7	1.78%	3,402	9.00%	26	27
7	10,000.0 хүртэл	30	0.9	0.10%	1,027.0	2.72%	22	8
	Нийт дүн	254	93.3	100%	37,818	100%	167	87

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд ХЗХ-ны салбарын гишүүдийн тоо 31.5, нийт активын хэмжээ 15.7 хувиар тус тус өслөө. "Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд бичил бизнесийн зээлийг дамжуулан олгох хөтөлбөрт 114 ХЗХ хамрагдсанаар салбарын хэмжээнд банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 10 дахин өсч 10.9 тэрбум төгрөгт хүрээд байна. Төсөл, хөтөлбөрөөс татан төвлөрүүлсэн эх үүсвэр нэмэгдсэнээр нийт активын хэмжээг өмнөх оны мөн үеэс 15.7 хувь, зээлийн үлдэгдлийг 16.6 хувиар тус тус өсгөж, банкны салбарт эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар дээшлүүлэх гол хүчин зүйл болжээ.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Зээлийн үзүүлэлт: Тайлант улирлын байдлаар ХЗХ-дын нийт зээлийн багц 72.8 тэрбум төгрөг байгаа нь активын 78.0 хувьтай, цэвэр зээл 71.0 тэрбум төгрөг байгаа нь активын 76.1 хувьтай тус тус тэнцэв.

Хүснэгт 23. ХЗХ-дын зээлийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Нийт 254 ХЗХ	Үүнээс:	
		Улаанбаатар хот	Орон нутаг
Зээлийн эхний үлдэгдэл	61,469,533.8	52,488,783.3	8,980,750.5
Олгосон зээл	188,468,920.1	174,394,904.9	14,074,015.2
Төлөгдсөн зээл	177,130,325.1	164,696,378.2	12,433,946.9
Зээлийн эцсийн үлдэгдэл	72,808,128.8	62,187,310.0	10,620,818.8

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Хүснэгт 24. ХЗХ-дын олгосон зээлийн зориулалт /мянган төгрөгөөр/

Олгосон зээлийн зориулалт	Зээлийн хэмжээ /мян төгрөг/	Тоо	Хувь
Нийт зээл	188,468,920.1	16,952	100.0%
Үүнээс: Иргэнд олгосон	80,312,284.4	16,934	42.6%
Хуулийн этгээдэд олгосон	108,156,635.7	18	57.4%
Бизнесийн зээл	169,855,640.9	8,421	90.1%
1. Үйлдвэрлэлийн зээл	13,496,321.3	2,227	7.2%
2. Үйлчилгээний зээл	144,396,564.7	2,758	76.6%
3. Газар тариалангийн зээл	742,216.6	243	0.4%
4. Мал аж ахуйн зээл	2,106,720.0	1,450	1.1%
5. Бусад	9,113,818.7	1,743	4.8%
Хэрэглээний зээл	18,613,279.3	8,541	9.9%
1. Өрхийн зээл	12,003,660.2	6,496	6.4%
2. Сургалтын төлбөрийн зээл	827,925.0	436	0.4%
3. Бусад	5,781,694.1	1,609	3.1%
Зээлийн үлдэгдэл	72,808,128.8	16,997	100%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад цэвэр зээлийн үлдэгдэл 9.9 тэрбум төгрөг буюу 16.1 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1.6 тэрбум төгрөг буюу 96.1 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 0.8 тэрбум төгрөг буюу 44.9 хувиар тус тус өссөн байна. Зээлийн багцыг өмнөх жилүүдтэй харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл 35. ХЗХ-дын зээлийн чанар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Тайлант улиралд ХЗХ-ны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 44.9 хувиар өссөн үзүүлэлттэй байв.

Өр төлбөр, өөрийн хөрөнгө: ХЗХ-дын эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.6 тэрбум төгрөгөөр буюу 15.7 хувиар өсчээ. Энэ өсөлтөд төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

хэмжээ нэмэгдсэн нь шууд нөлөөлжээ. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх жилүүдтэй харьцуулав. Үүнд:

Дүрслэл 36. ХЗХ-ын өр төлбөр, өөрийн хөрөнгө



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хадгаламжийн үйл ажиллагаа: Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 57.1 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 61.2 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 55.8 тэрбум төгрөг буюу 97.8 хувь нь хугацаатай хадгаламж байгаа бол 1.3 тэрбум төгрөг буюу 2.2 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

Хүснэгт 25. ХЗХ-ын хадгаламж /интервалаар/


№	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн /тэрбум төгрөг/	Нийт хадгаламжид эзлэх хувь	Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо
1	10,000,000.0 дээш	1	22.5	39.6%	1,274
2	1,000,000.0-10,000,000.0	8	23.5	41.2%	3,195
3	500,000.0-1,000,000.0	5	3.0	5.4%	1,134
4	100,000.0-500,000.0	22	4.9	8.8%	3,966
5	50,000.0-100,000.0	20	1.4	2.6%	2,356
6	10,000.0-50,000.0	56	1.3	2.3%	3,082
7	5,000.0-10,000.0	17	0.1	0.2%	472
8	5,000.0 хүртэл	83	0.1	0.3%	1,838
9	Хадгаламжгүй	42	-	0.0%	-
	Нийт хадгаламжийн дүн	254	57.1	100%	17,317

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 500.0 сая төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 14 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 49.1 тэрбумтөгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 86.1 хувь, хадгаламж эзэмшигчдийн 32.4 хувь нь тэдгээр ХЗХ-ны гишүүд байв. Нийт ХЗХ-дын 16.5 хувь буюу 42 ХЗХ хадгаламж татан төвлөрүүлээгүй.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулвал:

Дүрслэл 37. ХЗХ-ын хадгаламжийн өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгийн хөрөнгийн хэмжээ: Тайлант улиралд гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээ 10.4 тэрбум төгрөг байсан нь нийт эх үүсвэрийн 11.2 хувийг эзэлжээ.

Дүрслэл 38. ХЗХ-дын хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын өөрийн хөрөнгө 20.5 тэрбум төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 22.0 хувийг эзэлж байна. Үүнийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 26. ХЗХ-дын өөрийн хөрөнгө /интервалиар/

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн/тэрбум төгрөг/	Хувь
1	1,000,000.0 дээш	3	8.4	40.89%
2	500,000.0-1,000,000.0	4	2.9	14.34%
3	100,000.0-500,000.0	28	5.6	27.22%
4	50,000.0-100,000.0	22	1.5	7.58%
5	10,000.0-50,000.0	70	1.9	9.12%
6	10,000.0 доош	113	0.3	1.58%
7	Өөрийн хөрөнгөгүй	14	(0.15)	(0.73)%
Нийт өөрийн хөрөнгийн дүн		254	20.5	100%


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-ны ДНБ-д эзлэх активын хэмжээ 0.5 хувь, зээл 0.4 хувь, хадгаламжийн хэмжээ 0.3 хувь тус тус байна.

5.6 ХЗХ-ны үйлчилгээний хүртээмж

Тайлант улиралд нийт 254 ХЗХ Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 39. ХЗХ-дын тооны өөрчлөлт /графикаар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт 254 хоршоодын гишүүдийн тоо 37,818-д хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 9,068 гишүүнээр, өмнөх улирлаас 2,512 гишүүнээр тус тус өслөө.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Мөн нийт гишүүдийн 16,930 буюу 44.8 хувь нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 87 ХЗХ, 20,888 буюу 55.2 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 167 ХЗХ-дын гишүүд бөгөөд нийт гишүүдийн 17,317 буюу 45.8 хувь нь хадгаламж эзэмшигч гишүүд, 16,997 буюу 44.9 хувь нь зээлдэгч гишүүд байна.

Хүснэгт 27. Статистик мэдээлэл

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	НИЙТ ГИШҮҮД		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот 167 ХЗХ		Орон нутаг 87 ХЗХ	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт гишүүдийн тоо	37,818	100%	20,888	100%	16,930	100%
Үүнээс: эмэгтэй	20,977	55.5%	12,226	58.5%	8,751	51.7%
Үүнээс: гишүүн хуулийн этгээд	60	0.2%	43	0.4%	17	0.2%
Гишүүдийн насжилт	37,818	100%	20,888	100%	16,930	100%
18-35 насны	10,664	28.2%	6,082	29.1%	4,582	27.1%
36-45 насны	11,957	31.6%	6,174	29.6%	5,783	34.2%
46-55 насны	9,397	24.8%	5,200	24.9%	4,197	24.8%
55-аас дээш	5,800	15.3%	3,432	16.4%	2,368	14.0%
Гишүүдийн боловсрол	37,818	100%	20,888	100%	16,930	100%
Дээд	18,147	48.0%	12,608	60.4%	5,539	32.7%
Тусгай дунд	5,712	15.1%	3,089	14.8%	2,623	15.5%
Бүрэн дунд	8,054	21.3%	3,919	18.8%	4,135	24.4%
Дунд	4,468	11.8%	1,136	5.4%	3,332	19.7%
Бага	1,437	3.8%	136	0.7%	1,301	7.7%
Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо	17,317	45.8%	8,506	40.7%	8,811	52.0%
Хугацаатай хадгаламжтай	13,773	36.4%	6,478	31.0%	7,295	43.1%
Хугацаагүй хадгаламжтай	3,544	9.4%	2,028	9.7%	1,516	9.0%
Зээлдэгч гишүүдийн тоо	16,997	44.9%	8,341	39.9%	8,656	51.1%
Хэвийн зээлтэй	15,564	41.2%	7,699	36.9%	7,865	46.5%
Хугацаа хэтэрсэн зээлтэй	841	2.2%	357	1.7%	484	2.9%
Чанаргүй:	592	1.6%	285	1.4%	307	1.81%
Хэвийн бус зээлтэй	236	0.6%	81	0.4%	155	0.9%
Эргэлзээтэй зээлтэй	171	0.5%	77	0.4%	94	0.6%
Муу зээлтэй	185	0.5%	127	0.6%	58	0.3%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 167 ХЗХ-дын нийт актив 80.2 тэрбум төгрөгбайгаа нь салбарын нийт активын 86.0 хувь, орлого 12.7 тэрбум төгрөг болсон нь нийт орлогын 79.9 хувь, зардал 10.9 тэрбум мянган төгрөг байгаа нь нийт зардлын 81.5 хувийг тус тус эзэлж байна. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо огцом өссөн боловч тайлант үеийн ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс буурсан байна. ХЗХ-дын орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар өссөн байхад зардал 18.7 хувиар өссөн, мөн чанаргүй зээлийн хэмжээ 51.2 хувиар өссөн нь ашгийн хэмжээг бууруулахад нөлөөлжээ.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 87 ХЗХ-дын нийт актив 13.1 тэрбум төгрөг байгаа нь салбарын нийт активын 14.0 хувь, орлого 3.2 тэрбум төгрөг байгаа нь нийт орлогын 20.0 хувь, зардал 2.5 тэрбум төгрөг байгаа нь нийт зардлын 18.4 хувийг тус тус эзлэв.

5.7ХЗХ-ны үр ашигт байдал

2015 оны 3 дугаар улирлын эцэст ХЗХ-дын нийт орлого 15.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1.9 тэрбум төгрөг буюу 13.57 хувиар өссөн бол нийт зардал 13.4 тэрбум төгрөгт хүрч, 2.3 тэрбум төгрөг буюу 20.7 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан. Ингэснээр тайлант хугацаанд нийт цэвэр ашгийн хэмжээ 2.3 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 0.5 тэрбум төгрөг буюу 17.8 хувиар буурахад нөлөөлөв.


СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Нийт зардлын хэмжээ өсөхөд хүүгийн зардал 12.31 хувь, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 58.33 хувь, үйл ажиллагааны зардал (боловсон хүчний зардал 33.61, бусад зардал 34.81)/34.02 хувиар тус тус өссөн нь ашиг буурахад шууд нөлөөлжээ.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт орлого 15.9 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар өссөн байна. Энэ нь зээлийн хүүгийн орлого 1.9 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар, үйл ажиллагааны бусад орлого 0.4 тэрбум төгрөгөөр буюу 19.2 хувиар, үйл ажиллагааны бус орлого 0.05 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй холбоотой.

Тайлант улиралд ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 13.4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.2 тэрбум төгрөг буюу 19.9 хувиар өссөн байна. Үүнд хүүгийн зардал 0.9 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 0.3 тэрбум төгрөг буюу 58.3 хувиар, үйл ажиллагааны зардал 1.0 тэрбум төгрөг буюу 34.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Гэхдээ тайлант хугацаанд үйл ажиллагааны бус зардал 0.12 тэрбум төгрөг буюу 29.2 хувиар, татварын зардал 0.17 тэрбум төгрөг буюу 5.6 хувиар тус тус буурав.

Дүрслэл 40. ХЗХ-дын ашигт ажиллагаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд 138 ХЗХ-д 2.8 тэрбум төгрөгийн ашигтай, 15 ХЗХ ашиг, алдагдалгүй, 101 ХЗХ 0.25 тэрбум төгрөгийн алдагдалтай, салбарын хэмжээнд нийт 2.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан ба салбарын активын өгөөж 2.5 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 11.3 хувьтай байв. Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.3 тэрбум төгрөг буюу 10.8 хувиар буурчээ.

Нийтдээ 101 ХЗХ 250,891.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласанд тусгай зөвшөөрөл аваад 1 жилийн хугацаа хүрээгүй, үүсгэн байгуулахтай холбоотой эхлэлтийн зардлуудыг нөхөж чадаагүй 67 ХЗХ-ны алдагдал орчээ. Алдагдалтай ажиллаж байгаа 90 ХЗХ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ба тэдгээрийн алдагдлын хэмжээ 0.19 тэрбум төгрөг болсон нь нийт алдагдлын 77.2 хувийг эзлэв.

Шигтгээ 19:

ХЗХ-дын үйл ажиллагааны мөн чанар болон санхүүгийн үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, санхүүгийн технологийн шинэлэгдэвшлийг ашиглан алслагдсан дүүрэг, орон нутаг дахь иргэдийн санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

- Ядуурлыг бууруулах, зорилгод бүлэгт чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд хямд эх үүсвэрийн санхүүжилт, үйл ажиллагааны зардлын хяналтыг сайжруулснаар зээлийн хүүгийн түвшинг үе шаттайгаар бууруулах;
- Олон улсын бичил санхүүгийн туршилагыг нэвтрүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээг тэлэх зохицуулалтын орчинг боловсронгуй болгох.

В. Зээлийн батлан даалтын сан

УИХ-аас 2012 оны 2 дугаар сард Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, сангийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлэхээр хуульчилсан бөгөөд мөн оны 11 дүгээр сарын 06-ны өдөр бие даасан сан үүсгэн байгуулагдаад байна. 2015 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 394 ААН, иргэнд 68.5 тэрбумтөгрөгийн зээлийн багцад 27.9 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргасан.

Уг сангаас гаргасан батлан даалтын дээд хэмжээ 250 сая төгрөг, доод хэмжээ 600 мянган төгрөг байна. Зээлийн батлан даалтын сан нь 10 банк, 6 банк бус санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 8 банкаар дамжуулан батлан даалтын үйлчилгээг хүргэдэг. Нийт банкнаас олгосон дундаж зээлийн хэмжээ 174 сая төгрөг бол дунджаар зээлийн дүнгийн 47 хувьд нь батлан даалт гаргасан байна.

Хүснэгт 28. Батлан даалт гаргасан байдал

№	Банк, санхүүгийн байгууллага	Батлан даалтын тоо	Батлан даалттай зээлийн хэмжээ /төгрөгөөр/	Батлан даалтын хэмжээ /төгрөгөөр/	Батлан даалтын хувь
1	Голомт банк	96	18,726,010,000	7,919,187,000	28.3%
2	Капитал банк	52	7,315,900,000	2,960,493,400	10.6%
3	Төрийн банк	74	10,016,200,000	3,555,865,000	12.7%
4	ХААН банк	54	11,686,289,470	4,734,008,145	16.9%
5	Хас банк	85	9,042,000,000	4,135,681,500	14.8%
6	Худалдаа хөгжлийн банк	31	11,614,600,000	4,594,266,800	16.4%
7	ҮХО-н банк	1	140,000,000	80,880,800	0.3
8	Капитрон банк	1	20,000,000	3,100,000	0.01%
	НИЙТ	394	68,560,999,470	27,983,482,645	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2015 оны 3 дугаар улирлын эцэст батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн зээлийн тооомнөх оны мөн үеийнхээс 61.7 хувиар, батлан даалтын дүн нь 45.1 хувиар тус тус буурчээ. Энэ нь банкуудын зээлийн хязгаарлалт болон төсөл хөтөлбөрийн зээл олголтын хэмжээ буурсантай шууд холбоотой.

Хүснэгт 29. Батлан даалтын тоо

№	Үзүүлэлтүүд	2014Q3	2015Q3	Өөрчлөлт Бууралт (-), Өсөлт (+)
1	Батлан даалтын тоо	196	75	-61.7%
2	Батлан даалтын дүн	12,743	6,995	-45.1%
3	Зээлийн дүн	29,771	18,492	-37.9%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Батлан даалтын үйлчилгээний хүртээмжийн хувьд нийт батлан даалтын 64 хувь нь Улаанбаатар хотод гаргасан батлан даалт, 36 хувь нь орон нутгийн зээлд гаргасан батлан даалт байна. Нийт гаргасан батлан даалтын 5 хувь нь Өвөрхангай, 4 хувь нь Сэлэнгэ, 4 хувийг Ховд аймагт гаргасан.

Хүснэгт 30. Зээлийн батлан даалтын хүртээмж

№	Үзүүлэлтүүд	Батлан даалтын тоо	Батлан даалтын дүн /төгрөгөөр/	Батлан даалттай зээлийн дүн /төгрөгөөр/	Хувь
1	Орон нутаг	142	6,336,163,200	13,102,950,000	19.1%
2	Улаанбаатар	252	21,647,319,445	55,458,049,470	80.9%
	НИЙТ	394	27,983,482,645	68,560,999,470	100%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт батлан даалтын 25.2 хувь нь ҮХААЯ-ны төсөл, 27.5 хувь нь банкны, 24.5 хувь нь ЖДҮХС-ын төсөл, 22.8 хувь нь бусад эх үүсвэртэй зээл гаргажээ.

Хүснэгт 31. Санхүүжилтын эх үүсвэр

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлан даалтын тоо	Батлан даалтын хэмжээ	Батлан даалттай зээлийн хэмжээ	Хувь
1	Өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих сан	3	37,200,000	74,000,000	0.1%
2	Банк	133	7,701,172,945	18,370,089,470	27.5%
3	БХБЯ-ны төсөл	1	250,000,000	1,000,000,000	0.9%
4	ЖАЙКА	29	3,740,591,000	8,560,600,000	13.4%
5	ЖДҮХС-ын төсөл	88	6,866,854,300	17,033,300,000	24.5%
6	ҮХААЯ-ны төсөл	67	7,063,595,000	18,487,810,000	25.2%
7	ХЭДС	50	140,485,000	263,600,000	0.5%
8	Монгол 888 төсөл	12	1,672,389,000	3,832,600,000	6.0%
9	НЖДҮХС	10	496,195,400	909,000,000	1.8%
10	АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл	1	15,000,000	30,000,000	0.1%
	Дүн	394	27,983,482,645	68,560,999,470	100%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Шигтгээ20:

Олон улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинэ, хандлагуудаас харахад хөгжиж буй болон хөгжингүй эдийн засагтай орнуудад эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангах, ажилгүйдлийг бууруулах үндсэн хэрэгсэл нь жижиг дунд үйлдвэрлэлийн салбар /ЖДҮ/-аас ихээхэн хамааралтай байна. ЖДҮ-ийг хөгжүүлэхэд түүний санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн үр ашигтайгаар хуваарилснаас хамаардаг. Жижиг дунд үйлдвэрлэлийг санхүүжүүлэхэд төрийн зохицуулах байгууллагуудын өмнө тодорхой бэрхшээлүүд үүсэн бий болдог. Учир нь улс орны жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн түвшин ялгаатай, удирдлага, зохион байгуулалт, маркетинг, санхүүжилтийн болон борлуулалтын сувгууд өөр байдагтай холбоотойгоор ЖДҮ-ийн санхүүжилтийн хамгийн оновчтой хувилбарыг сонгоход бэрхшээлтэй.

2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын дараагаас Базелийн хорооноос арилжааны банкуудад тавигддаг шаардлага, нөхцлүүдийг өндөрсгөж, эрсдэлтэй салбаруудад олгож буй зээлийн хэмжээг бууруулахыг зөвлөсөн нь эргээд жижиг дунд үйлдвэрлэлд олгож буй банкны зээлийн хэмжээг бууруулах шалтгаан болж байна.

Мөн Олон улсын үнэт цаасны зохицуулах байгууллагуудын холбоо /IOSCO/-оос гишүүн орнуудын ЖДҮ-ийн санхүүжилтийн талаарх судалгааг 2015 онд хийсэн бөгөөд үүнд санхүүжилтийн асуудлыг зээлийн санхүүжилтээс илүүтэйгээр санхүүгийн шинэ технологийг ашиглан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх хэлбэрүүдийг эрчимтэй хөгжүүлэж буй талаар бичигдсэн бөгөөд энэ нь тухайн орны үнэт цаасны зах зээлийн хөгжлөөс ихээхэн хамааралтайг дурджээ.

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Үнэт цаасны зах зээл сул хөгжсөн орнуудад ЖДҮ-ийн санхүүжилтийг оновчтой шийдвэрлэх, үүргийн баталгааг хангах чиглэлээр Зээлийн батлан даалтын сан /ЗБДС/-гийн тогтолцоог амжилттай хэрэгжүүлдэг институт. Банк болон зээлдэгчийн хооронд байнгын мэдээллийн зөрүүтэй байдал үүсдэг ба банк зээл олгоходоо тухайн зээлдэгчийн хэрэгжүүлэхээр зорьж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжих болон эргэн төлөгдөх магадлалыг чанд нягтлан зээл олгох эсэхийг шийдэхэд ЗБДС нь дээрх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах үндсэн хэрэгсэл болж байна.

ЗБДС нь хөгжиж буй эдийн засагтай орнуудын жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд үндсэн түлхэц нь болж өгдөг бөгөөд зээлдэгч болон зээл олгогчийн хооронд үүсч буй санхүүжилтийн зөрүү /financing gap/-г шийдвэрлэдэг.

Мөн ЗБДС нь зээлдэгчийн барьцаа хөрөнгийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх, зээлийн мэдээллийн санг үүсгэх, дан ганц банкны зуучлалд суурилсан санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх боломжийг олгодгоороо санхүү, эдийн засгийн салбарт томоохон давуу талыг бий болгож байна. Өндөр хөгжилтэй орнуудад зээлийн батлан даалтыг урт хугацааны санхүүжүүлтийг нэмэгдүүлэх байдлаар ашигладаг бол хөгжиж буй орнуудад зээлийн зах зээлийг өргөжүүлэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. ЗБДС-аас үзүүлэх үйлчилгээний төрлийн хувьд банкнаас олгох зээл болон зээлийн тодорхой хувьд батлан даалт гаргах, батлан даалт авч буй ЖДҮ-т санхүүгийн зах зээлийн мэдээлэл болон санхүүгийн тайлан бэлтгэх болон холбогдох хуваарьт сургалт явуулах зэрэг үйлчилгээг үзүүлдэг.

ЗБДС-гийн өмчлөлийн дараах 3 төрлийн бүтэц байна. Үүнд:

- Төрийн өмчлөлийн;*
- Төр болон хувийн хэвилийн хамтарсан; /төрийн оролцоо 50-аас доошгүй хувь/*
- Хувийн хэвилийн сан. /Энэ хэлбэрийн батлан даалтын сангийн хэлбэрт батлан даалтын сан нь орон нутаг, нутаг дэвсгэрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллаж, гишүүн ЖДҮ-үүдийн үйл ажиллагаа, зээлжих зэрэглэлийг үнэлэх, зээл олгогч санхүүгийн байгууллагад зөвлөмж өгөх зэрэг чиг үүргийг давхар хэрэгжүүлдэг/*

Хувийн хэвилийн батлан даалтын сан нь шууд ба шууд бусаар хамтран байгуулсан батлан даалтын сан гэсэн 2 хэлбэртэй. Хувийн хэвилийн санхүүгийн байгууллагуудын шууд хамтран байгуулсан сан нь эргэн төлөгдөөгүй зээлийн эрсдлийг хамтран хариуцаж, сангийн удирдлагыг зөвшилцөн томилдог. Шууд бус оролцоотой хэлбэрийн батлан даалтын санг үүсгэн байгуулагчид бус тухайн улсын худалдаа аж үйлдвэрийн танхим нь удирддаг аж. Харин төрийн өмчлөлийн ЗБДС-ийн үйл ажиллагааны хяналт, удирдлагыг холбогдох яам, эсхүл төв банк зэрэг санхүүгийн хяналт, зохицуулалтын чиг үүрэг бүхий төрийн байгууллага хэрэгжүүлдэг.

Олон улсын туршлагаас харахад, ЖДҮ-ийн борлуулалтын хэмжээ, эсхүл ажиллагсдын тоо зэрэг тогтоосон шалгуураас хамаарч ЗБДС нь зээл хүсэгч компанийн технологи, зээлжих чадварыг шалгаж үнэлгээ гаргах ба банк нь тус корпорацийн үнэлгээг үндэслэж зээл олгодог. ЗБДС, банк болон ЖДҮ-ийн харилцааг зохицуулсан 3 төрлийн бүтэц байна.

- Retail guarantee system /ЗБДС болон банк хоёул тухайн зээлийн эрсдлийн үнэлгээг хийж, батлан даалт олгох эсэх нь шийдэгддэг/;*
- Portfolio guarantee system /зээлийн эрсдлийн үнэлгээ, баталгаа гаргах эсэхийг зээлийн багцаар нь шийддэг/;*
- Wholesale guarantee system*

Манай орны хувьд эхний хэлбэрийг ашиглаж байгаа бөгөөд цаашид portfolio guarantee system –ийг нэвтрүүлэх шаардлагатай.

Хавсралт 1. Үнэт цаасны салбарын 2015 оны 3 дугаар санхүүгийн тайлангийн нэгтгэл

1. Хувьцаат компанийн санхүүгийн байдлын тайлан нэгтгэл

(Нийт 173 хувьцаат компани)

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Хувь
1	ХӨРӨНГӨ			
1.1	Эргэлтийн хөрөнгө			
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	115,895,071.3	102,629,923.30	2.43
1.1.2	Дансны авлага	307,443,611.7	319,589,836.60	7.57
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	25,282,557.3	8,523,666.00	0.20
1.1.4	Бусад авлага	39,480,782.5	63,837,941.90	1.51
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	14,557,310.2	15,312,202.10	0.36
1.1.6	Бараа материал	431,952,164.1	427,860,168.90	10.14
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	430,279,071.8	466,036,400.90	11.04
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	3,613,924.2	5,606,538.30	0.13
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	2,537,577.1	2,322,702.10	0.06
1.1.10		-	1,276,065.00	0.03
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,371,042,070.2	1,412,995,445.10	33.47
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	0	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,197,081,692.4	2,276,656,888.40	53.93
1.2.2	Биет бус хөрөнгө	25,614,582.2	24,020,937.60	0.57
1.2.3	Биологийн хөрөнгө	2,428,308.3	2,328,900.70	0.06
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	190,101,287.4	242,765,459.80	5.75
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	5,684,659.3	7,718,065.40	0.18
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	8,635,439.4	9,366,253.30	0.22
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	5,944,454.2	5,560,337.30	0.13
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	204,332,772.9	232,549,190.90	5.51
1.2.9		4,743,538.9	7,494,765.30	0.18
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,644,566,735.0	2,808,460,798.70	66.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,015,608,805.2	4,221,456,243.80	100.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	0	-
2.1	Өр төлбөр		0	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		0	-
2.1.1.1	Дансны өглөг	300,543,184.6	324,527,154.20	7.69
2.1.1.2	Цалингийн өглөг	6,949,968.2	7,997,252.40	0.19
2.1.1.3	Татварын өр	32,046,613.7	40,025,260.60	0.95
2.1.1.4	НДШ - ийн өглөг	7,761,200.1	14,759,051.50	0.35
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	173,128,534.0	161,768,769.50	3.83
2.1.1.6	Хүүний өглөг	11,644,325.4	17,215,578.60	0.41
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	20,361,849.2	28,540,188.50	0.68
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	31,384,771.1	58,586,462.50	1.39
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	2,789,559.3	2,776,040.40	0.07
2.1.1.1	Бусад богино хугацаат өр төлбөр	54,852,605.3	53,670,133.60	1.27
0				
2.1.1.1	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	0	-
1				
2.1.1.1		39,341.9	48,927.80	0.00
2				

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

2.1.1.1 3	Богино хугацаат өр төлбөрийн дүн	641,501,952.8	709,914,819.60	16.82
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	0	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	816,736,979.1	791,431,422.10	18.75
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	31,841,218.5	34,010,782.00	0.81
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	749,460.7	1,591,508.40	0.04
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	191,233,136.3	278,136,213.90	6.59
2.1.2.5		10,937,373.2	325,000.00	0.01
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,051,498,167.8	1,105,494,926.40	26.19
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,693,000,120.6	1,815,409,746.00	43.00
	Эздийн өмч		0	-
2.3	Өмч	810,494,130.1	929,316,316.60	22.01
2.3.1	- төрийн	629,683,210.7	730,547,722.20	17.31
2.3.2	- хувийн	57,063,570.1	52,735,009.40	1.25
2.3.3	- хувьцаат	123,747,349.3	146,033,585.00	3.46
2.3.4	Халаасны хувьцаа	425,928.8	405,955.10	0.01
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	78,262,269.0	61,234,867.00	1.45
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	714,245,724.2	720,824,527.10	17.08
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	118,800.1	118,800.10	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	634,467,655.4	672,114,957.30	15.92
2.3.9	Хуримтлагдсан ашиг	85,446,034.6	22,842,984.80	0.54
2.3.10		-	0	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,323,460,542.2	2,406,046,497.80	57.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,016,460,662.8	4,221,456,243.80	100.00

2. Хувьцаат компанийн орлого, үр дүнгийн тайлан нэгтгэл

(Нийт 173 хувьцаат компани) /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,786,811,478.70	1,367,552,401.50
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,534,914,399.70	1,166,216,080.10
3	Нийт ашиг (алдагдал)	251,897,079.00	201,336,321.40
4	Түрээсийн орлого	9,410,349.40	8,828,892.90
5	Хүүний орлого	5,197,491.30	3,715,710.30
6	Ногдол ашгийн орлого	1,578,441.80	703,307.90
7	Эрхийн шимтгэлийн орлого	366,551.80	33,971.80
8	Бусад орлого	45,162,343.80	30,309,362.40
9	Борлуулалт, маркетингийн зардал	76,754,153.20	54,751,592.50
10	Ерөнхий ба удирдлагын зардал	162,098,884.70	132,654,908.80
11	Санхүүгийн зардал	22,214,529.60	18,299,678.70
12	Бусад зардал	36,615,310.00	25,566,361.80
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-27,775,093.30	-29,557,639.40
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-11,414,855.00	-1,050,642.70
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,322.90	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	208,011.10	-9,539.80
17	Бусад ашиг (алдагдал)	-4,173,528.80	-2,782,406.90
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-27,222,763.50	-19,745,203.90
19	Орлогын татварын зардал	6,847,903.30	9,294,385.90
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-34,070,666.80	-29,039,589.80
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-34,070,666.80	-29,039,589.80
23	Бусад дэлгэрэнгүй орлого	46,924.50	-4,995.80
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	46,924.50	-4,995.80
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-34,023,742.30	-29,044,585.60
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-11.60	0.00

3. Үнэт цаасны компаниудын санхүүгийн байдлын тайлангийн нэгтгэл

(Нийт 46 үнэт цаасны компани)

/мянган төгрөг/

Үзүүлэлтүүд		
	Өмнөх үе	Тайлант үе
Хөрөнгө	58 070 353 208.19	58 752 448 403.97
Эргэлтийн хөрөнгө	38 756 166 217.33	38 205 719 253.11
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	22 722 837 126.33	15 297 214 406.63
Касс дахь мөнгө	1 174 336 588.13	1 674 268 993.53
Төгрөгөөр	1 156 450 854.77	1 665 642 269.74
Валютаар	17 885 733.36	8 626 723.79
Банкин дахь мөнгө	21 398 832 635.19	13 574 452 266.26
Төгрөгөөр	20 483 893 091.11	12 158 034 327.10
Валютаар	914 939 544.08	1 416 417 939.16
Мөнгөтэй адилтгах хөрөнгө	149 667 903.01	48 493 146.83
Дансны авлага (цэврээр)	4 129 202 303.82	4 055 101 823.24
Дансны авлага	4 141 928 043.86	4 067 827 563.28
Найдваргүй авлагын хасагдуулга	-12 725 740.04	-12 725 740.04
Татвар, НДШ-ийн авлага	1 091 440.97	11 236 879.31
ААНОАТ-ын авлага	949 562.14	2 449 242.98
НӨАТ-ын авлага	0.00	8 570 474.91
НДШ-ийн авлага	141 878.83	217 161.42
Бусад авлага	1 358 126 492.06	1 489 133 052.57
Холбоотой талаас авах авлага	21 022 823.17	172 374 060.99
Ажиллагчдаас авах авлага	820 995.20	28 820 995.20
Ногдол ашгийн авлага	0.00	0.00
Хүүний авлага	0.00	0.00
Богино хугацаат авлагын бичиг	0.00	0.00
Бусад талуудаас авах авлага	1 336 282 673.69	1 287 937 996.38
Санхүүгийн хөрөнгө	8 925 305 341.34	14 755 440 283.51
Арилжааны үнэт цаас	6 431 686 189.12	10 722 565 963.05
Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	67 747 206.00	85 893 546.62
Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас	1 560 288.00	1 328 228 280.00
Борлуулахад бэлэн үнэт цаас	2 459 342 746.22	2 653 816 037.84
Хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-29 472 280.00	-29 472 280.00
Дериватив	-5 558 808.00	-5 591 264.00
Бараа материал	55 685 732.13	43 084 156.13
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	653 749 507.00	1 867 469 574.55
Урьдчилж төлсөн зардал	651 881 569.60	1 288 196 767.25
Урьдчилж төлсөн түрээс, даатгал	1 867 937.40	1 625 137.40
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр	0.00	577 647 669.90
Бусад эргэлтийн хөрөнгө	58 730 789.68	45 054 159.16

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	851 437 484.00	641 984 918.02
Эргэлтийн бус хөрөнгө	19 314 186 990.86	20 546 729 150.87
Үндсэн хөрөнгө (цэврээр)	4 862 396 293.46	5 518 295 941.66
Үндсэн хөрөнгө	6 557 179 822.06	7 504 714 542.37
Газрын сайжруулалт	690 585 524.00	690 585 524.00
Барилга, байгууламж	3 429 163 994.27	4 341 687 870.58
Машин, тоног төхөөрөмж	180 363 784.97	222 085 625.01
Тээврийн хэрэгсэл	736 154 492.68	736 154 492.68
Тавилга, эд хогшил	594 163 824.62	532 089 138.90
Компьютер, бусад хэрэгсэл	361 810 148.73	394 840 554.87
Бусад үндсэн хөрөнгө	564 938 052.79	587 271 336.33
Хуримтлагдсан элэгдэл (-)	-1 694 783 528.60	-1 986 418 600.71
Биет бус хөрөнгө (цэврээр)	170 760 865.56	165 784 415.37
Биет бус хөрөнгө	210 304 613.05	210 655 875.02
Зохиогчийн эрх	0.00	0.00
Компьютерийн програм хангамж	92 315 693.08	93 120 067.19
Патент	0.00	0.00
Барааны тэмдэг	0.00	0.00
Тусгай зөвшөөрөл	38 762 847.00	38 762 847.00
Газар эзэмших эрх	12 340 000.00	12 340 000.00
Бусад биет бус хөрөнгө	66 886 072.97	66 432 960.83
Хуримтлагдсан элэгдэл (-)	-39 543 747.49	-44 871 459.65
Дуусаагүй барилга	0.00	0.00
Урт хугацаат хөрөнгө оруулалт	14 213 170 011.42	14 794 788 973.42
Хойшлогдсон татварын хөрөнгө	67 859 820.42	67 859 820.42
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
Өр төлбөр ба эздийн өмч	58 070 353 208.19	58 752 448 403.97
Өр төлбөр	7 659 531 838.49	6 572 745 164.13
Богино хугацаат өр төлбөр	7 219 311 309.27	6 100 613 760.91
Дансны өглөг	3 847 872 585.20	3 766 978 688.02
Төлөгдөх хугацаандаа байгаа	3 843 432 265.18	3 764 672 516.51
Хугацаа хэтэрсэн	4 440 320.02	2 306 171.51
Цалингийн өглөг	50 035 642.05	100 223 105.88
Татварын өр	132 553 574.58	77 887 748.12
ААНОАТ өр	53 650 212.76	3 901 188.54
НӨАТ-ын өр	10 373 944.02	3 537 570.76
ХХОАТ-ын өр	39 547 720.76	56 936 803.06
ОАТ-ын өр	5 543.99	147 940.76
Бусад татварын өр	28 976 153.05	13 364 245.00
НДШ-ийн өглөг	13 998 140.49	48 463 320.01
Богино хугацаат зээл	993 506 480.37	360 942 130.40
Төлөгдөх хугацаандаа байгаа	993 506 480.37	360 942 130.40
Хугацаа хэтэрсэн	0.00	0.00
Хүүний өглөг	-9 170.82	-9 170.82
Ногдол ашгийн өглөг	678 468 889.00	0.00
Урьдчилж орсон орлого	69 194 820.71	57 090 005.52
Нөөц (өр төлбөр)	59 001 880.00	67 731 488.00
Бусад богино хугацаат өр төлбөр	286 819 795.56	302 711 934.81
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	1 087 868 672.13	1 318 594 510.97
Урт хугацаат өр төлбөр	440 220 529.22	472 131 403.22

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Урт хугацаат зээл	251 210 901.67	272 282 775.67
Гадаадын байгууллагаас шууд авсан зээл	0.00	0.00
Гадаадын байгууллагаас дамжуулан авсан зээл	0.00	0.00
Дотоодын эх үүсвэрээс авсан зээл	251 210 901.67	272 282 775.67
Нөөц (өр төлбөр)	0.00	0.00
Хойшлогдсон татварын өр	165 627.55	165 627.55
Бусад урт хугацаат өр төлбөр (гадаад, дотоодын зах зээлд гаргасан бонд, өрийн бичиг)	188 844 000.00	199 683 000.00
Эздийн өмч	50 410 821 369.70	52 179 703 239.84
Өмч	37 188 218 019.68	39 499 817 579.68
Төрийн	250 000 000.00	250 000 000.00
Хувийн	36 259 469 419.68	38 571 068 979.68
Хувьцаат	678 748 600.00	678 748 600.00
Халаасны хувьцаа	0.00	0.00
Нэмж төлөгдсөн капитал	7 933 826 237.14	8 159 697 093.14
Сангууд	8 311 565.00	8 311 565.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1 514 672 128.03	1 522 685 461.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1 323 393 017.71	1 323 393 017.71
Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	191 279 110.32	199 292 443.77
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	2 473 520.00	2 473 520.00
Гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтээс үүссэн зөрүү	-37 663 092.00	-37 663 092.00
Бүртгэлийн валютыг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн зөрүү	0.00	0.00
Бусад	40 136 612.00	40 136 612.00
Эздийн өмчийн бусад хэсэг	1 625 414 592.86	1 549 040 431.38
Хуримтлагдсан ашиг, алдагдал	2 137 905 306.99	1 437 677 589.16
Тайлангийн үе	276 179 545.15	-700 227 717.82
Өмнөх үеийн	1 861 725 761.84	2 137 905 306.99

4. Үнэт цаасны компаниудын орлого, үр дүнгийн тайлангийн нэгтгэл

(Нийт 46 үнэт цаасны компани)

/мянган төгрөг/

Үзүүлэлтүүд	Нийт 46 ҮЦК	
	Өмнөх үе	Тайлант үе
Үйл ажиллагааны орлого	3 746 636 829.27	2 299 175 872.68
Брокерын үйл ажиллагааны орлого	1 699 053 766.14	1 018 742 233.42
Дилерийн үйл ажиллагааны орлого	6 032 028.00	1 981 345.96
Андеррайтерийн үйл ажиллагааны орлого	366 355 615.77	481 258 643.77
Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого	1 021 850 192.58	640 974 219.20
Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	457 336 377.65	93 647 710.14
Бусад үйл ажиллагааны орлого	201 832 996.21	57 064 935.71
Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого	-5 824 147.08	5 506 784.48
Түрээсийн орлого	173 955 388.71	112 502 438.91
Хүүний орлого	1 257 254 095.97	1 354 663 321.12
Ногдол ашгийн орлого	7 068 898.57	20 006 397.27
Хувьцааны ногдол ашиг	7 068 898.57	8 942 001.27
Хараат болон хамтарсан компаниас олсон ашиг	0.00	11 064 396.00
Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
Бусад орлого	655 055 441.34	421 618 210.89
Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал	5 394 035 356.57	4 559 144 519.00
Ажиллагчдын цалингийн зардал	2 246 501 561.47	1 976 209 061.89

СЗХ | Санхүүгийн зах зээлийн 2015 оны III улирлын тойм

Удирдлагын цалингийн зардал	1 237 770 500.41	1 122 998 468.80
Бусад ажиллагчдын зардал	1 008 731 061.06	853 210 593.09
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ, ЭМД-ын зардал	221 646 238.87	198 792 908.88
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	728 860 026.85	482 976 049.15
Зохицуулалтын үйлчилгээний хөлс	44 733 806.82	23 501 944.30
Гишүүнчлэлийн хураамж	65 404 555.80	81 279 800.00
Арилжааны шимтгэл (МХБ)	125 124 468.69	60 277 808.86
Арилжааны шимтгэл (ҮЦТГТХТ)	74 589 639.26	39 701 132.81
Бусад	419 007 556.28	278 215 363.18
Томилолтын зардал	222 371 991.15	100 922 483.22
Бичиг хэргийн зардал	35 754 327.45	19 199 339.36
Шуудан холбооны зардал	101 919 052.94	70 761 889.53
Мэргэжлийн үйлчилгээний зардал	203 151 547.06	140 193 892.79
Сургалтын зардал	35 104 048.54	35 705 403.37
Сонин сэтгүүл захиалгын зардал	161 000.00	799 700.00
Даатгалын зардал	676 985.01	4 976 618.19
Ашиглалтын зардал	156 433 809.58	114 076 540.10
Засварын зардал	70 012 426.59	39 380 295.14
Элэгдэл, хорогдлын зардал	456 460 959.34	372 950 775.60
Түрээсийн зардал	569 314 874.18	342 904 891.71
Харуул хамгааллын зардал	2 622 550.00	15 624 727.27
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	170 712 066.20	89 076 722.73
Тээврийн зардал	6 705 417.41	4 274 649.11
Шатахууны зардал	51 064 409.12	34 990 704.95
Хүлээн авалтын зардал	14 325 845.55	39 360 370.60
